

АЛСЫН ХАРАА  
**2050**

МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ  
ХӨГЖЛИЙН БОДЛОГО

ЭДИЙН ЗАСАГ

4

МОНГОЛ  
УЛСЫН  
ХӨГЖЛИЙН  
БОДЛОГО  
ХАРАА  
2050



# АЛСЫН ХАРАА 2050

МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ  
**ХӨГЖЛИЙН БОДЛОГО**



ЭДИЙН ЗАСАГ

4

Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрдээ хүрсэн, дундаж давхарга зонхилсон, ядуурал эрс буурсан, эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, дотоод хэрэгцээгээ өөрсдөө хангадаг, экспорт эрчимжсэн, хөрөнгө оруулалт, хуримтлалын чадавхаа бүрдүүлсэн, олон тулгуурт эдийн засагтай улс болно.



## ЭДИЙН ЗАСАГ

**Ерөнхий редактор:**

Пүрэвийн ЗОХИХСҮРЭН  
Баянгэрэлийн БАТБААТАР

**Редакцын баг:**

Пүрэвийн ЗОХИХСҮРЭН  
Даваадоржийн ЭНХБОЛДБААТАР  
Өлзийбүрэнгийн ЖАМЬЯН  
Ганбаатарын ОТГОНЖАРГАЛ

**Туслан гүйцэтгэсэн:**

Галбадрахын БИЛГҮҮН  
Бат-Ирээдүйн МӨНХ-ЭРДЭНЭ

**Зөвлөх:**

Түвшний ДОРЖ  
Намсрайн БАТНАСАН  
Бавуудоржийн ДАВААСҮРЭН  
Мягмарсүрэнгийн БАЯРМАГНАЙ  
Отгоншарын БАТНАЙРАМДАЛ  
Галсандоржийн БАТХҮРЭЛ  
Доожавын ГАН-ОЧИР  
Авиurmэдийн ДАВААСҮРЭН  
Жавхлангийн ГАНБАЯР  
Төмөртогоогийн ДЭЛГЭРНАРАН  
Маширын ЭРДЭНЭБАЯР  
Булжинсүрэнгийн ОЧГЭРЭЛ  
Батжаргалын СҮНДЭРЬЯА  
Даваадоржийн БАЛЖИННЯМ  
Батмөнхийн БАТДАВАА

**Дизайнер:**

Нямжавын БЯМБАЦОГТ  
Жаргалсайханы МӨНХСАЙХАН

**Гэрэл зураг:**

МРА.МН  
Жамбалын БАТБААТАР /БАКУ/  
Хишигтогтохын ТУШИГ

**Хавтасны зураг:**

Батбаатарын ЦОЛМОНБАЯР

Улаанбаатар хот 2022 он

Copyright © ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Энэхүү бүтээлийн зохиогчийн эрхийг хуулиар хамгаалсан болно. Бүтээлийг ашгийн бус зорилгоор олон нийтэд түгээх, хуваалцах, ашиглах, хэрэглэх эрхтэй бөгөөд гагцхүү эх сурвалжийг дурдана уу.

Хэвлэлийн эхийг Нэпко хэвлэлийн газарт бэлтгэж,  
"Мөнхийн үсэг" ХХК-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

ISBN: 978-9919-511-63-0



## ГАРЧИГ

ОЛОН ТУЛГУУРТ ЭДИЙН ЗАСАГ	8
ЧИНЭЭЛЭГ МОНГОЛ	14
ЭДИЙН ЗАСГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛҮҮД	20
Хариуцлагатай уул уурхай, хүнд үйлдвэр	22
Хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэр	26
Найдвартай, хүрэлцээтэй эрчим хүч	30
Тээвэр логистик	36
Үндэсний онцлогтой аялал жуулчлал	42
Бүтээлч үйлдвэрлэл, мэдээллийн технологи	44
УХААЛАГ САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛ	48
БҮС НУТГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА	52
ӨРСӨЛДӨХ ЧАДВАРТАЙ БРЭНД БҮТЭЭГДЭХҮҮН	56
ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САН	60

## ЭДИЙН ЗАСГИЙН ИРЭЭДҮЙ

Сүүлийн 30 жилд Монгол Улс ардчилсан нийгэм, зах зээлийн тогтолцоонд шилжих түүхэн шилжилтийг амжилттай хийж, хөгжлийн амаргүй сорилтуудыг даван туулж, эдүгээ хүний хөгжил харьцангуй өндөр түвшин бүхий дэлхийн дунджаас доогуур орлоготой орон болон хөгжиж байна. Гэвч Монгол Улс эдийн засгийн өрсөлдөх чадварын үзүүлэлтээр дэлхийн 141 орноос 102, бизнес эрхлэх орчны үзүүлэлтээр 190 орноос 81, хил давсан худалдааны үзүүлэлтээр 190 орноос 143 дугаарт гэх зэрэг хөгжлийн олон үзүүлэлтээр бус нутгийн улс орнууд, дэлхийн дунджаас доогуур түвшинд байна.

Улс орон бүр эдийн засгийн түргэн хурдацтай өсөлтөд чиглэсэн дунд, урт хугацааны бодлого төлөвлөж, хүн амын дундаж давхаргыг тэлэх зорилт хэрэгжүүлж буй энэ цаг үед Монгол Улс хөрш орнууд болон харилцаа, хамааралтай эдийн засгуудтай өөрийн давуу тал, бодит боломж, бие даасан чадавх, үндэсний онцлог хийгээд орчин үеийн хөгжлийн хандлага, технологийн дэвшилд түшиглэж хамтран ажиллах шаардлагыг зүй ёсоор дэвшүүлэн тавьж байна.

Иймд манай орон эдийн засгийн бодлогын хүрээнд ойрын жилүүдэд нэг талдаа өсөн нэмэгдэж буй гадаад өрийг бууруулах, нөгөө талд эдийн засгийн өсөлтийг хангаж хуримтлал үүсгэн, амьдралын чанарыг дээшлүүлж, дундаж давхаргыг тэлэх, улмаар эдийн засгийн тогтвортой хөгжлийн үндэс суурийг тавих гэсэн амаргүй зорилтуудыг хэрэгжүүлэх цаг хугацаа бидний өмнө байна.



ЭДИЙН ЗАСАГ

## ОЛОН ТУЛГУУРТ ЭДИЙН ЗАСАГ

Эдийн засгийн биедаасан байдлаа хангаж хөгжих, байгальд ээлтэй, хүний аюулгүй, амгалан амьдрах боломжийг бүрдүүлсэн тогтвортой хөгжлийн загварыг бий болгох нь эдийн засгийн аюулгүй байдлыг хангах үндсэн нөхцөл мөн. Эдийн засгийн олон тулгуурт, оновчтой бүтцийг бий болгох, хөрөнгө оруулалтын тэнцвэртэй бодлого явуулах, санхүүгийн салбарын аюулгүй байдлыг баталгаажуулах, эрчим хүч, эрдэс баялгийн болон гадаад худалдаа, интеграцын асуудлаар оновчтой бодлого баримтална.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал.  
3.2 Эдийн засгийн аюулгүй байдал

Монгол Улс сүүлийн 30 жилд ардчилсан нийгэм, зах зээлийн тогтолцоонд шилжих шилжилтийн хүнд үеийг амжилттай туулсан ч хөгжлийн амаргүй сорилтууд тулгарч, эдүгээ дэлхийн дунджаас доогуур орлоготой, буурай орны тоонд багтаж байна.


Монгол Улс зах зээлд шилжсэн өхний жилүүдэд аж үйлдвэрийнхээ түүхий эдийг хангаж байсан хөдөө аж ахуйн нэгдэл, сангийн аж ахуйнуудыг тарааж хувьчлан, аж үйлдвэр хөдөө аж ахуйн салбарыг холбож байсан бэлтгэн нийлүүлэлт, тээвэр логистикийн дэд бүтцээ орхигдуулж, улмаар олон салбарууд уналтад орсон.

Монгол Улсын Дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн 1/4, нийт экспортын 90 гаруй хувь нь байгалийн эрдэс, түүхий эд олборлох уул уурхайн салбарт ногдож байна. Ийнхүү улсын эдийн засаг цөөн салбараас хэт хамааралтай, өрсөлдөх чадвар сул, боловсруулах аж үйлдвэр хөгжлийн хувьд хоцрогдмол, нэмүү өртөг шингээсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэггүйгээс улс орны эдийн засаг гадаад зах зээлээс хараат, эмзэг тогтвортгүй байна.

Аялал жуулчлалын өрсөлдөх чадвараар 136 орноос 102, Дэлхийн банкны Бизнес эрхлэх хялбар байдлын үзүүлэлтээр Монгол Улс 190 орноос 74, хил дамнасан худалдаа эрхлэхэд



Зураг 1. Эдийн засгийн өнөөгийн төлөөв байдал



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо, 2022

тулгарч буй бэрхшээлээр 143, цахилгаан, эрчим хүчний хангамжаар 152, маргаан шийдвэрлэх процессын үзүүлэлтээр 150 дугаарт эрэмбэлэгдэж байна.

Гадаад зах зээлийн нөхцөл байдал, байгаль цаг уураас шууд хамааралтай эдгээр салбаруудын хэт тэлэлт нь эдийн засаг, төсвийн тогтвортгүй байдлын үндсэн шалтгаан нь болж байна. Эдийн засаг өсөж байх үед Монгол улс нь цикл дэмжсэн санхүүгийн бодлого авч хэрэгжүүлж, олон улсаас ихээхэн хэмжээний зээл валютаар авсан нь макро эдийн засгийн томоохон эрсдэлүүдийг бий болгосон. Гадаад өр өндөр түвшинд хүрснээс үүдэн зээлжих зэрэглэл доогуур, эрсдэлтэй нөхцөл байдалд байгаа тул гадаадын хөрөнгө оруулалт бага, гадаад зээл өндөр хүүтэй байна. Макро эдийн засгийн энэхүү хүндрэлүүд нь аж үйлдвэрлэлийн салбарт хүндээр тусаж, үндэсний мөнгөний чадвар, инфляц зэрэгт нөлөөлж байна.

Монгол Улс жилд 6.1 тэрбум ам.долларын бараа бүтээгдэхүүн гаднаас худалдан авч байна. Дунджаар 1 тэрбум ам.долларыг газрын тосны бүтээгдэхүүнд, 605 сая ам.долларыг хүнсний бүтээгдэхүүнд, 140 сая ам.долларыг эрчим хүчний хэрэглээнд зарцуулдаг. Тиймээс эдийн засгийн салбарыг үндэс сууриар нь шинэчлэн өөрчлөхөд алс хэтийг харж, оновчтой төлөвлөсөн, зөв


зохицуулалт бүхий хөгжлийн бодлого, түүний эрчимтэй, үр дүнтэй, үл тасалдах зогсолтгүй, хэлбэрэлтгүй хэрэгжилт юунаас чухлаар тавигдаж байна.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг тодорхойлохдоо эхний үе шат буюу 2021-2030 онд орчин үеийн эдийн засгийн судалгаанд өргөн ашиглах болсон мэдээллийн томоохон бааз суурь, программ хангамжид суурилан макро эдийн засгийн тооцооллыг хийдэг Ерөнхий тэнцвэрийн динамик загварыг, хоёр, гуравдугаар үе шат буюу 2031-2050 он хүртэлх хугацаанд салбар хоорондын тэнцэлд тулгуурласан оновчлолын динамик загварыг ашиглаж, 2019 онд хийсэн бөгөөд 2018 он хүртэлх Монгол Улсын эдийн засгийн суурь үзүүлэлтүүдийг ашигласан болно. Тухайн үед манай улсын эдийн засгийн дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий хэмжээ 11.7 тэрбум ам.доллар, нэг хүнд ногдох ДНБ 3,879 ам.долларын хэмжээнд байсныг дурдах учиртай.

Уг тооцоололд хөгжлийн өнөөгийн хандлага, өсөлт, өөрчлөлтийн хурд, төрийн оролцоо, зохицуулалтын түвшнийг хүртэл хэвээр хадгалсан “суурь” хувилбарыг ерөнхий тооцоолол

Зураг 2. Дотоодын нийт бүтээгдэхүүн ба нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэтийн тооцоо

### МОНГОЛ УЛСЫН ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН БА НЭГ ХҮНД НОГДОХ ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭТИЙН ТООЦОО (2018 оны зэрэгцүүлэх үнээр)



Монгол Улсын ДНБ-ийн хэмжээ тухайн оны үнээр 2025 онд 23.9 тэрбум ам.доллар, 2030 онд 47.6 тэрбум ам.доллар, 2050 онд 209.0 тэрбум ам.долларт хүрнэ. Нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ тухайн оны үнээр 2025 онд 6,520 ам.доллар, 2030 онд 12,054 ам.доллар, 2050 онд 38,359 ам.доллар болно.

Эх сурвалж: Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын төсөл боловсруулах Ажлын хэсэг, 2019



болгон тооцож, тус суурь хувилбар дээрээ хүн, байгалийн аль алинд ээлтэй, баялгийг үр өгөөжтэй, зүй зохистой ашиглах тогтвортой хөгжлийг хангах, дэлхий дахины чиг хандлага болж буй “ногоон эдийн засаг”-ийн үзэл баримтлалыг харгалзан үзсэн хоёр дахь тооцооллыг боловсруулсан. Ингээд “ногоон” хөгжлийн зарчмуудыг харгалзсан хувилбар дээрээ үндэсний хэмжээний үйлдвэрлэл, бизнесийн болон дэд бүтцийн томоохон төсөл, хөтөлбөрүүдийг нэмж бодсон гурав дахь тооцооллыг гаргасан бөгөөд энэ хувилбараар хөгжлийн бодлогын зорилго, зорилт, хүрэх үр дүнг тодорхойлсон.

Тиймээс хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд Тавантолгой, Оюутолгой, Дорноговийн цахиурын, Цагаансуваргын, Хармагтайн зэрэг томоохон уул уурхайн төслүүд, зэсийн баяжмал, газрын тос, кокс боловсруулах болон металлургийн үйлдвэр, нүүрс угаах, боловсруулах, метан хий гаргаж авах, ган төмөрлөгийн, жонш баяжуулах, алт цэвэршүүлэх хүнд үйлдвэрүүд, Багануур, Тавантолгойн цахилгаан станцууд, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц болон III, IV цахилгаан станцуудын хүчин чадлыг нэмэгдүүлэх эрчим хүчиний төслүүд, Алтанбулаг-Дархан-Уул-Улаанбаатар, Ховд-Улаангом, Чойбалсан-Баруун-Үрт,

Зураг 3. Гадаад орчны байдал

### 2050 онд дэлхийн хамгийн хүчтэй 10 эдийн засагт Хөгжих бүй орнууд давамгайлна

Худалдан авах чадварын тэнцвэрээр тооцсон

	2016	2050	
БНХАУ	1	①	БНХАУ
АНУ	2	2	Энэтхэг
Энэтхэг	3	3	АНУ
Япон	4	4	Индонез
Герман	5	5	Бразил
ОХУ	6	⑥	ОХУ
Бразил	7	7	Мексик
Индонез	8	8	Япон
Англи	9	9	Герман
Франц	10	10	Англи

E7 Economies

G7 Economies

### Парисын хэлэлцээрт нэгдсэн улс орнуудын нүүрсний хэрэглээний өөрчлөлт

#### ЕВРОПЫН ХОЛБОО



Хүлэмжийн хийн ялгаруулалтыг 2030 он гэхэд 40 хувиар бууруулна. /1990 оны түвшнээс/

#### БНЭУ



2030 он гэхэд ДНБ-ийн нэгж нүүрстөрөгчийн ялгаруулалтыг 30-35 хувь бууруулна.

#### ГЕРМАН



2038 он гэхэд нүүрсээр ажилладаг цахилгаан эрчим хүчийг зогсоно.

#### БНХАУ



Анхдагч эрчим хүчинд эзлэх нүүрсний хэмжээг 2030 онд 50 хувь бууруулна. (2060 он 0 хувь)

#### ФРАНЦ



2021 он гэхэд нүүрсээр ажилладаг цахилгаан станцуудаа хаана.

#### ИХ БРИТАНИ



2025 оноос өмнө нүүрсээр ажилладаг бүх цахилгаан байгууламжуудыг хаана.

Баяндалай-Шивээхүрэн, Өлгий-Хөх эрэг, Сонгино-Тэс-Арц суурь зэрэг улс, бүс, орон нутгийн автозам, Тавантолгой-Зүүнбаян, Зүүнбаян-Хангимандал, Нарийнсухайт-Шивээ хүрэн, Тавантолгой-Гашуунсухайт, Сайншанд-Баруун-Урт-Хөөт зэрэг төмөр замын бүтээн байгуулалтын төслийг хэрэгжүүлснээр зорилтот үр дүнд хүрнэ.

Улс орны эдийн засгийг үндсэндээ нуруундаа үүрч буй уул уурхайн салбар эрдэс, түүхий эдийн дэлхийн зах зээлийн нөхцөл байдал, ханшийн хэлбэлзлээс шууд хамааралтай байгаа

Зураг 4. Монгол Улсын Экспортын бүтэц



**90%**

нэмүү өртөг  
шингээлгүйгээр  
экспортолдог

**90%**

импортоор  
худалдан авдаг



нь тогтвортой байдлын нэг хүчин зүйл болдог. Эдийн засгийг төрөлжүүлэн хөгжүүлж, олон “хөл”-тэй буюу олон тулгууртай болгох, дэд бүтэц, тээвэр логистикийн сүл байдлыг халж, эргэлтийн хурдыг нэмэгдүүлэх, бие даасан, хараат бус, эрсдэл даах чадвартай эдийн засгийн чадавх бий болгох зэрэг стратегийн шинжтэй зорилго, зорилтыг тодорхойлсон урт хугацааны бодлогыг хэрэгжүүлэх нь хөгжлийг хангах найдвартай үндэс болж чадах юм.

Эдийн засгийн өсөлт жилд дунджаар 6 хувийн өсөлттэй байхаар тооцож, эдийн засгийг төрөлжүүлэх “олон тулгуур”-ын бодлого хэрэгжсэнээр ДНБ-д боловсруулах аж үйлдвэрийн эзлэх хувь 27.4, тээвэр логистикийн салбарынх 11.6 хувь болж өсөх бөгөөд уул уурхай, олборлох салбарын үйлдвэрлэл нэмэгдсэнээр нэмүү өртөг шингээж, ДНБ-д эзлэх хувь нь хэвээр хадгалагдах төлөвтэй. Түүнчлэн дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, үндэсний үйлдвэрлэл, брэнд бүтээгдэхүүн хөгжүүлэх замаар өнөөдөр 7.0 тэрбум ам.доллароор хэмжигдэж буй экспортын хэмжээг оны дүнгээр 2025 онд 14.0 тэрбум, 2030 онд 29.7 тэрбум, 2050 онд 139.9 тэрбум ам.долларт хүргэхээр тооцсон.

Тодорхойлсон зорилгодоо хүрэхийн тулд эдийн засгийн бодлогынхоо хүрээнд ойрын жилүүдэд эдийн засгийн өсөлтийг хангаж, улмаар өсөн нэмэгдэж буй гадаад өрийг багасгах, цаашлаад тогтвортой хөгжлийн суурийг тавихад чиглэсэн зорилтуудаа эрчимтэй хэрэгжүүлэх нь чухал. Макро түвшинд тодорхой зорилго чиглэлтэй, мөчлөг сөрсөн, зардал хэмнэсэн, өндөр хэлбэлзлээс үүдэлтэй сөрөг үр дагавруудыг хаах, гадаад өр зээлийг бууруулахад чиглэсэн бодлогоо нэн тэргүүнд эхлүүлж, дунд хугацаанд эдийн засгаа тогтвортжуулах, урт хугацаандаа тогтвортой хөгжлийг хангаж, эрсдэл багатай, олон тулгуурт эдийн засгийг бий болгох ерөнхий замын зургийг урт хугацааны хөгжлийн бодлогод тусгасан нь зүй ёсны шийдэл гэж хэлж болно. Харин эдийн засгийн өсөлтөд чиглэсэн бизнес төслүүд, нийгмийн салбаруудыг хөгжүүлэх төсөл арга хэмжээ болон тэдгээрийг дэмжих дэд бүтцийн бүтээн байгуулалтуудад зарцуулах хөрөнгө оруулалт, санхүүжилтийн зохицтой тэнцвэрийг бий болгох нь эдийн засгийг сэргээх үндсэн суурь нөхцөл болохыг эрдэмтэд сануулж буй. Түүнчлэн олборлох үйлдвэрлэлийн салбараас орж буй орлогыг эдийн засгийн бусад салбар руу, нийгмийн хөгжлийг дэмжих шаардлагатай бус нутгийн руу чиглүүлэх ухаалаг бодлого, зохицуулалтын арга хэмжээг авах зайлшгүй шаардлагатай байна.

Эдийн засгийн өсөлт жилд дунджаар 6 хувийн өсөлттэй байхаар тооцож, эдийн засгийг төрөлжүүлэх “олон тулгуур”-ын бодлого хэрэгжсэнээр Монгол Улсын ДНБ-ийн хэмжээ тухайн оны үнээр 2050 онд 209.0 тэрбум ам.долларт, нэг хүнд ногдох ДНБ-ийн хэмжээ 2050 онд 38,359 ам.доллар болно.

ЭДИЙН ЗАСАГ

# ЧИНЭЭЛЭГ МОНГОЛ

**ЗОРИЛТ 4.1.** Макро эдийн засгийн тогтвортой орчныг бүрдүүлж, дундаж давхаргыг нийгмийн зонхилох бүлэг болгоно.

ХӨГЖЛИЙН ҮЕ ШАТ • ХҮРЭХ ҮР ДҮН

**I ҮЕ ШАТ | 2021-2030**

Засгийн газрын хугацаа туссан гадаад өр төлбөрийг макро эдийн засгийн тогтвортой байдлыг алдагдуулахгүйгээр шийдвэрлэж, үр ашгийг дээшлүүлэх, макро эдийн засгийн тэнцвэрт байдлыг хангаж, эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх үе

**II ҮЕ ШАТ | 2031-2040**

Үндэсний хуримтлал бүхий макро эдийн засгийн орчныг бүрдүүлэх үе

**III ҮЕ ШАТ | 2041-2050**

Макро эдийн засгийн гадаад, дотоод тэнцвэрийг хангаж, бүрэн ажил эрхлэлттэй, инфляцын нам түвшин бүхий макро эдийн засгийн орчныг бүрдүүлж, дундаж давхаргыг нийгмийн зонхилох бүлэг болгох үе


Иргэдийн орлого, ажлын байрны асуудал эдийн засгийн өсөлтгүйгээр бүрэн шийдэгдэх боломжгүй. Эдийн засгийн хүртээмжтэй өсөлтийг амьдралын чанарын эерэг өөрчлөлтөөр л хэмжих учиртай.

Эдийн засгийнхаа өсөлтийг хангахгүйгээр дундаж давхаргыг тэлэх, иргэдийн орлого, ажлын байр, бусад салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зэрэг суурь асуудлыг шийдэх боломжгүй. Дундаж давхаргыг нийгмийн зонхилох бүлэг болгоход макро эдийн засгийн тогтвортой орчин зайлшгүй чухал юм. Бүрэн ажил эрхлэлттэй, инфляцын түвшин бага, төсөв алдагдалгүй, улсын өрийн түвшин тогтвортой, төлбөрийн тэнцэл хангагдсан, гадаад валютын ханшийн огцом хэлбэлзэлгүй макро эдийн засгийн тогтвортой орчин бүрдүүлэх нь чухал. Инфляц хэт өндөр байвал эдийн засаг өссөн ч иргэдийн бодит худалдан авах чадвар нэмэгдэхгүй, импортоос хэт хамааралтай хэвээр байх бөгөөд төгрөгийн ханш гадаад валютын эсрэг огцом хэлбэлзэж, энэ нь иргэдийн худалдан авах чадварыг бууруулна. Түүнчлэн макро эдийн засгийн тогтвортой байдал гадаад, дотоодын бизнес эрхлэгчдэд шинээр хөрөнгө оруулалт хийх, үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд ихээхэн эрсдэл үүсгэдгээс аливаа бизнест томрох, тэлэх боломж олгодоггүй.





Зураг 5. Засгийн газрын өр, ДНБ-ий харьцаа, төсөөлөл



Энэ тооцооллыг 2023 онд төлөгдхөн Хөгжлийн банкны гадаад бондын 30 тэрбум иен болон 500 сая ам.долларын бондын эргэн төлөлтийг дахин санхүүжүүлэх хувилбараар тооцлоо.

Эх сурвалж: Сангиийн яам, 2022.

Макро эдийн засгийн орчныг тогтвортжуулахын тулд юуны өмнө Засгийн газрын өрийн удирдлагыг сайжруулж, дарамтыг бууруулан, үр ашигтай, хариуцлагатай төсвийн тогтолцоо бий болгох, төрхувийн хэвшилийн түншлэлийг дэмжиж, хөрөнгө оруулалтын болон бизнесийн таатай орчин бүрдүүлэх, эрсдэл даахуйц валютын нөөц бий болгох, эдийн засгийн өсөлтийг тогтвортжуулж, хөдөлмөр эрхлэлт, иргэдийн худалдан авах чадварыг нэмэгдүүлэх зорилт дэвшүүлсэн. “Чинээлэг Монгол” зорилтын үндэс суурь болж буй юм. Эдгээрийг хэрэгжүүлэхийн тулд төсвийн сахилга бат, санхүү, мөнгө, зээлийн бодлого, зохицуулалтыг сайжруулж, татварын бодлогыг оновчтой болгон, орлогын бааз суурийг өргөжүүлж, эдийн засгийн мөчлөг сөрсөн төсвийн бодлого хэрэгжүүлэх, тэнцлийг ашигтай, улмаар хуримтлалтай болгох хүртэлх багц арга хэмжээг хэрэгжүүлнэ. Засгийн газраас олон улсын зах зээлд гаргасан үнэт цаасны өгөөжийг нэмэгдүүлэх чиглэлээр ажиллаж, дахин санхүүжилт хийхээс өөрөөр арилжааны нөхцөлтэй гадаад үнэт цаас гаргахаас татгалзана. Дахин санхүүжилтэд урт хугацаанд жигд төлөгдхөн эх үүсвэр ашиглах, өрийн багц дахь хувьсах хүүтэй гадаад зээлийг ашигтай нөхцөлд тогтмол хүүтэй зээлд шилжүүлэх зэрэг бодлогын алхмуудыг хийхийн зэрэгцээ олон улсын зэрэглэл тогтоогч байгууллага, хөрөнгө оруулагчдыг мэдээллээр тогтмол хангаж, хамтарч ажиллах замаар Монгол улсын зээлжих зэрэглэлийг сайжруулна.

## ИНФЛЯЦЫН ТҮВШИН

2022 (5 cap) 15.1%

2030 6.0%

2050 2.0%



ЭДИЙН ЗАСАГ

## ЧИНЭЭЛЭГ МОНГОЛ

2021 оны II улирлын  
байдлаар Монгол Улсын  
нийт гадаад өр 28.0 тэрбум  
амдолларт хүрч, ДНБ-ий  
220 хувьтай тэнцэж байна.

Эдийн засаг өсөж байх үед Монгол Улс мөчлөг дэмжсэн санхүүгийн бодлого хэрэгжүүлж, олон улсаас ихэехэн хэмжээний зээл валютаар авсан нь макро эдийн засгийн томоохон эрсдэлийг бий болгоод байна. 2024 он дуусталх хугацаанд нийт 12.5 тэрбум амдоллартой тэнцэх гадаад төлбөр төлөхөөр хүлээгдэж байна. Энэ нь манай улсын зээлжих зэрэглэл буурахад нөлөөлж, гадаадын шууд хөрөнгө оруулалт бага, гадаадын зээл өндөр хүүтэй байна. Макро эдийн засгийн энэхүү хүндрэлүүд аж үйлдвэрлэлийн салбарт хүндээр тусаж үндэсний мөнгөний худалдан авах чадвар, инфляциад нөлөөлж байна.

Улс орныг “чинээлэг” болгох зорилтын нэн тэргүүнд хийх ажил бол гадаадын зээл, хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн зардал, үр өгөөжийн тооцооллыг сайтар хийж, хэрэгжих хугацаа сунгагдах, зардал нэмэгдэх, үр өгөөж буурах зэрэг эрсдэл үүсгэхгүй байх, зөвхөн үр ашигтай төслийг санхүүжүүлэх тогтолцоог бий болгох явдал юм. Бодит сургамж, даван туулсан сорилт, туршлагаас урган гарсан энэхүү үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд төсөл, арга хэмжээний зардал, үр нөлөө болон болзошгүй эрсдэл, өгөөж, эрэмбийг урьдчилан тогтоох загварыг боловсруулж мөрдүүлэх бөгөөд ингэснээр хөгжлийн түншүүдтэй хамтын ажиллагааны бодлогоо тодорхойлж, итгэлцэл, ойлголцлын түвшнийг ахиулан, харилцан ашигтай ажиллах нөхцөл бүрдэх юм. Дээр дурдсанчлан эдийн засгийн мөчлөг серсөн төсвийн бодлого явуулахын тулд уул уурхайн салбарын бүтээгдэхүүний эрэлт их, үнэ өндөр үед бий болсон нэмэлт орлогоос тодорхой хэсгийг “Ирээдүйн өв сан”-д хадгалж, сангийн удирдлага, засаглал, хариуцлага, ил тод байдлыг хангахад чиглэсэн олон улсын сайн туршлагыг нэвтрүүлэн, хөрөнгийг арвижуулах оновчтой, эрсдэлгүй, өгөөжтэй менежмент хэрэгжүүлж, байгалийн баялгийн өгөөжийг тэгш хуваарилах тогтолцоог бүрдүүлнэ.

Зураг 6. Гадаад өрийн эрсдэлийг бууруулах дунд хугацааны стратеги

Бодит эдийн засгийн  
салбарт Засгийн  
газрын гадаад зээлийн  
хөрөнгийг тулхүү  
ашиглах

“Тогтвортой хөгжлийн  
зорилт”-д нийцсэн  
өрийн хэрэгслийг  
судлан, нэвтрүүлэх

Дахин санхүүжилтээс  
бусад зориулалтаар  
Засгийн газрын  
гадаад үнэт цаас  
арилжаалахгүй байх





Ажилгүйдлийг бууруулж, нийгмийн дундаж давхаргыг тэлэх, улмаар өрхийн амьжирагааны түвшнийг тогтвортой хадгалахын тулд инфляцыг бага түвшинд байлгах төсөв, мөнгөний зохистой бодлого явуулах шаардлагатай. Үүний тулд инфляцыг нам, тогтвортой хадгалах үйл ажиллагааны үр нелөөг тооцох загвар, баримт нотолгоонд суурилсан бодлогын хувилбаруудыг боловсруулж, тэдгээрээс тухайн нехцэл байдалд тохируулан богино, урт хугацаанд харилцан уялдаатай хэрэгжүүлэх суурь бэлтгэлийг хангаж эхлээд байна. Түүнчлэн энэ зорилтыг хангахын тулд гадаад валютын албан нөөцийн хэмжээг жилийн импортын хэрэгцээг хангахуйц түвшинд хүргэж, эрсдэл даах чадварыг дээшлүүлэх, дотоодын зах зээлээс алт худалдан авах ажиллагааг боловсронгуй болгож, хэмжээг нэмэгдүүлэх, мөнгөний нийлүүлэлт, төсвийн зарлага, зээл олголтыг удирдах зэрэг олон талын арга хэрэгслийг санхүүгийн системийн бүтэц, онцлог шинж чанарт тохируулан зохистой ашиглахаар төлөвлөсөн.

Манай улсын санхүүгийн систем харьцангуй эмзэг байна. Энэ эмзэг байдлыг бууруулж, тогтвортой байдлыг бэхжүүлэх үүднээс эрсдэлээс урьдчилан сэргийлэх тогтолцоо бүрдүүлэх нь нэн чухал юм. Өр зээл хэт нэмэгдэхээс урьдчилан сэргийлэх, хөрвөх чадварын эрсдэлийг удирдах, санхүүжилтийн төвлөрлийг хязгаарлах, санхүүгийн дэд бүтцийн бэрхшээлийг эсэргүүцэх чадамжийг бэхжүүлэх бодлого хэрэгжүүлснээр хөгжлийн хөдөлгөгч хүч байх үргээ энэ салбар бүрнэх хангаж ажиллах нехцэл бүрдэнэ. Эдгээр зорилтын хүрээнд Төв банк өрийн дарамтыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх ба санхүүгийн системийн эрсдэлээс сэргийлэх тогтолцоо бүрдэж, бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмж нэмэгдсэнээр зээлийн хүү хөгжингүй орнуудын түвшинд хүрч бууран, тогтвортой хадгалагдана.

Улс орныхоо түвшинд бид сүүлийн 15 жилд дунджаар дотоодын нийт бүтээгдэхүүний 15 хувь буюу 2.4 тэрбум ам.доллартой тэнцэх хэмжээний орлогоосоо давсан зарлагатай явж ирсэн байна. Өөрөөр хэлбэл өрх гэрийн түвшинд ч, улс орны түвшинд ч бид орлогоосоо давсан хэрэглээтэй байж, энэ нь өрийн дарамтад орох эрсдэлийг үүсгэж ирсэн.

Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжааг тогтмолжуулах

“МЕГА” төслүүдийн санхүүжилтэд баталгаа гаргаж, дэмжих

Гадаад өр төлбөрийн хуваарийг валютын нөөцтэй уялдуулах



Эх сурвалж: Сангийн яам, 2021.

## ӨГӨӨЖТЭЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ



Гадаадын хөрөнгө оруулалтын эдийн засагт үзүүлж буй голлох нөлөөлөл нь шинэ технологи нэвтрүүлж, бүтээмжийг нэмэгдүүлэх юм. Гэхдээ хөрөнгө оруулалт татсан салбар, эдийн засгийн бүтэц, салбаруудын хоорондын хамаарлаас шалтгаалан үр нөлөө нь ялгаатай. Монгол Улсын хөрөнгө оруулалтын бүтцийг харахад уул уурхайн салбар дийлэнх хувийг эзэлж байна. Иймд уул уурхайн бус эдийн засгийн тэргүүлэх салбаруудад хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

Гадаадын хөрөнгө оруулалтын эрэлт хэрэгцээг салбараар болон байршилаар тодорхойлж, тэдгээрийн онцлогт тохируулан хөрөнгө оруулалт татах, хөрөнгө оруулагчдыг дотоодын аж ахуйн нэгжүүдтэй холбох тогтолцоог оновчтой хэлбэр, бүтэц, аргаар зохион байгуулж, хамтран ажиллах орчныг сайжруулна.

Зураг 7. Монгол Улс дахь гадаадын шууд хөрөнгө оруулалт



Эх сурвалж: ЭЗХЯ, 2022




## ҮНДЭСНИЙ ХУРИМТЛАЛ



Монгол Улсын үндэсний хуримтлал нь дотоод хөрөнгө оруулалт, хэрэглээг хангахад хүрэлцэхгүйгээс ургал тэнцлийн өндөр алдагдалтай явж ирснийг гадаадын шууд хөрөнгө оруулалт болон гадаад өрөөр санхүүжүүлж ирсэн. Гадаадын шууд хөрөнгө оруулалт орж ирэх нь олон эерэг дам нөлөөг бий болгож, өсөлтөд эргээр нөлөөлөн, нэг хүнд ногдох ДНБ өссөн хэдий ч үндэсний нийт орлого (УНО)-ын нэг хүнд ногдох хувь хэмжээ бага байгаа дүр зураг ажиглагдаж эхэллээ. Энэ нь гадаадын шууд хөрөнгө оруулалтаас манай улсад үлдэх үр өгөөжид онцгой анхаарах шаардлагатайг харуулж байна. Улсын гадаад өрийн хэмжээ ч жил дараалан өссөөр ДНБ-ий 220 хувьд хүрээд байгаа нь манай эдийн засгийн эмзэг байдлыг нэмэгдүүлж, хүүгийн дарамтыг ихэсгэж байна. Иймд эдийн засгийн бодлогын хүрээнд ойрын жилүүдэд нэг талдаа өсөн нэмэгдэж буй гадаад өрийг бууруулах, нөгөө талд эдийн засгийн өсөлтийг хангаж хуримтлал үүсгэх, нийгмийн суурь үйлчилгээг тэгш, хүртээмжтэй болгох, эдийн засгийн тогтвортой хөгжлийн үндэс суурийг тавих гэсэн амаргүй зорилтуудыг хамтатган хэрэгжүүлэхийг зорьж байна.

Зураг 8. Төсөө, мөнгө, тэрбум төгрөгөөр



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, 2022

ЭДИЙН ЗАСАГ

# ЭДИЙН ЗАСГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛҮҮД

**ЗОРИЛГО 4.2.** Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгоно.

хөгжлийн үе шат • хурэх үр дун

**I ҮЕ ШАТ | 2021-2030**

Эдийн засгийн бүтцийн шинэчлэлийг эхлүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, импортыг орлох болон экспортод чиглэсэн хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх үе

**II ҮЕ ШАТ | 2031-2040**

Хүнд, хөнгөн болон эрчим хүч, барилгын материалын үйлдвэрлэлийн хэрэгцээг дотоодоос бүрэн хангаж, экспортод чиглэсэн үйлдвэрлэлийг тулхүү хөгжүүлэх шатанд шилжих үе

**III ҮЕ ШАТ | 2041-2050**

Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, олон тулгуурт тогтвортой эдийн засагтай улс болох үе

Эдийн засгийн хөгжлийг хангах нэн тэргүүний зорилт бол дан ганц уул уурхайгаас хэт хамааралтай өрөөгөл бүтцийг шинэчлэх явдал юм. Олон тулгууртай төрөлжсөн, тогтвортой эдийн засгийг бий болгохын тулд тэргүүлэх чиглэлүүдээ тодорхойлж, хөрөнгө оруулалт, нөөц чадавх, үйл ажиллагааны уялдааг тэдгээр салбар, чиглэлүүдэд тэгш хуваарилж ажиллах нь чухал билээ.

Монгол Улсын амьжиргааны эх үүсвэрийн 93 хувь нь нүүрс, алт, зэс, төмрийн хүдэр зэрэг нөхөн сэргээгдэхгүй баялгаас бүрддэг. Энэ бэрхшээлийг давахын тулд эдийн засгийг төрөлжүүлэн хөгжүүлэх нь хөгжлийн бодлогын үндэс билээ.

Ирэх 30 жилд манай улс нэмүү өртөг шингээсэн уул уурхай, стратегийн мега төслүүд, хөдөө аж ахуй, боловсруулах аж үйлдвэр, эрчим хүч, тээвэр, логистик, төрөлжсөн аялал жуулчлал, түүнийг дагасан үйлчилгээ, жижиг, дунд үйлдвэрлэл, мэдлэгжсэн бүтээлч үйлдвэрлэлийг эдийн засгийн тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлэх зорилт тодорхойлсон. Мөн хөдөө аж ахуй, тээвэр логистик, төрөлжсөн аялал жуулчлалын салбарыг бүс, орон нутгийн онцлогт суурилан хөгжүүлнэ.

Эдийн засгийн тэргүүлэх салбаруудаа дэмжихэд дэд бүтцээ шийдвэрлэх шаардлагатай. Тавантолгой-Гашуунсухайт,





Зураг 9. Эдийн засгийн тэргүүлэх чиглэлүүд



Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг барьснаар Монгол Улс тээврийн зардлаас жилд 600-900 сая ам.доллар хэмнэж, нийт экспортын хэмжээг 30 орчим хувиар нэмэгдүүлэх боломжтой. Авто замын төслүүдийг ач холбогдоор нь эрэмбэлж, стратегийн орд газруудыг хилийн боомтуудтай холбох юм. Өнөөдрийн байдлаар манай улс эрчим хүчний хэрэглээнийгээ 25 хувийг гаднаас авч, жил бүр дунджаар 140 сая ам.доллар зарцуулж байна. Иймд эрчим хүчний өсөн нэмэгдэж буй дотоодынхао хэрэгцээг бүрэн хангах зорилгоор Тавантолгойн цахилгаан станц, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцыг барьж, Улаанбаатар хотын эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.

Жилд дунджаар 605 сая ам.долларын хүнсний бүтээгдэхүүнийг гаднаас худалдан авч буй манай улс хүнсний үйлдвэрлэлийн өрсөлдөх чадвараар 192 орноос 180 дугаарт эрэмбэлэгдэж байна. Тиймээс импортыг орлох, экспортын баримжаатай хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн цоо шинэ тогтолцоог бүрдүүлж, малын түүхий эдийг боловсруулах үйлдвэр болон логистик, тээвэрлэлтийн суурь төвүүдийг үе шаттай барьж байгуулна.

Монголд ирэх гадаад жуулчдад үүсдэг бэрхшээл, хүнд суртал, хариуцлагагүй байдлыг арилгаж, цахим элчин сайдын яам байгуулан, цахим виз олгох, агаарын тээврийг либералчилна. Бахархам түүх, баялаг соёлынхао өв уламжлалд түшиглэн Монгол хүний авьяас ур чадварт тулгуурлаж бүтээлч эдийн засгийн салбарыг хөгжүүлнэ. Соёлын менежментийг шинэ түвшинд хүргэн, урлаг соёл, киноны үйлдвэрлэлийг дэлхийн түвшинд гаргаж, эдийн засгийн үр өгөөжтэй байх зорилтыг дэвшүүлж байна.

#### Олон тулгуурт эдийн засаг

Монгол Улс ирэх 30 жилд эдийн засгийг төрөлжүүлэн хөгжүүлэх тэргүүлэх чиглэлүүдээ тодорхойллоо. Эдгээр салбаруудад хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлж, бусад салбаруудтай уялдуулан хөгжүүлнэ.

	<b>САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ (2021)</b>
	Дотоодын нийт бүтээгдэхүүний <b>22%</b>
	Нийт экспортод эзлэх хувь <b>92%</b>
	Гадаадын шууд хөрөнгө оруулалтын хувь <b>64%</b>
	Аж үйлдвэрт эзлэх хувь <b>71%</b>
	Ашиглалт болон Хайгуулын тусгай зөвшөөрөл <b>2,642</b>
	Улсын төсөвт төвлөрүүлж буй орлого <b>2.6 ИХ НАЯД ₮</b>

Эх сурвалж: УУХҮЯ, 2022

#### Баялаг

Монгол Улсад өнөөгийн байдаар 80 гаруй төрлийн ашигт малтмал бүхий 1,000 гаруй орд газар, 8,000 гаруй илрэл бүртгэгдээд байна. Эдгээрээс зөвхөн 17 нэр төрлийн ашигт малтмалын нөөцийн одоогийн үнэлгээ 3.1 их наяд ам.доллартой тэнцэж байна.



#### ЭДИЙН ЗАСГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛҮҮД

## ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭР

Монгол Улсыг уул уурхайн орон гэх болж, энэ салбар манай эдийн засгийн орлогын үндсийг бүрдүүлж байгаа нь гашуун үнэн. Нэгэнт үүссэн өнөөгийн нөхцөл байдалд үндэслэн уул уурхайн салбарыг эдийн засгийн тэргүүлэх чиглэлийн нэг хэвээр байхаар тусгалаа. Гэхдээ нэмүү өртөг шингээсэн, гүн боловсруулалттай, хариуцлагатай, байгаль орчны баримжаатай болж шат ахих хувилбараар хөгжлийн бодлогодоо тусгасан. Геологийн судалгаа, нарийвчилсан хайгуулын ажлын үр дүнд улсын хэмжээнд 80 гаруй төрлийн ашигт малтмалын 1,000 гаруй орд, 10,000 гаруй илрэл тогтоогдсон байдаг. Голлох ашигт малтмалын нөөцийг авч үзвэл 175.5 тэрбум тонн нүүрсний, 57 сая тонн зэсийн, 2,493 тонн алтны, 1.2 тэрбум тонн төмрийн, 170 мянган тонн ураны нөөц бүртгэгдээд байна. Энэхүү нөөц баялагт тулгуурлан экспорт болон эдийн засгийн хүчин чадлыг нэмэгдүүлж, дотоод хуримтлалыг өсгөх замаар эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангах боломж бий.

Зураг 10. Уул уурхайн салбарын төлөв байдал



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо, 2022



Зураг 11. Уул уурхайн салбарт баримтлах стратеги



Жилд дунджаар 20 орчим тонн алт олборлож байхад алтны нөөцийн хэмжээ жилд 2.0 тонн орчмоор нэмэгдэж байгаагаар хайгуул судалгааны ажил ашиглалт, олборлолтоосоо хоцорч байгааг харж болно.

Иймд Геологийн судалгааны ажлыг эрчимжүүлж, Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд ашигт малтмалын тархалтын зүй тогтол, минерагений судалгаа хийж, эрдэс баялгийн хэтийн төлөвийн үнэлгээ өгөх, улс орны эрдэс баялгийн нөөцийг нэмэгдүүлэхэд чиглэсэн ашигт малтмалын эрлийн болон хөрөнгө оруулагчдын сонирхлыг татахуйц бус, зангилаа, талбайг ялгах арга хэмжээг зохион байгуулж, үндэсний геологи, эрдэс баялгийн нэгдсэн мэдээллийн санг баяжуулж, төрөлжсөн байдлаар зурган болон тоон (цахим орчны шаардлагад нийцүүлэн) хэлбэрээр бүрдүүлнэ.

Цаашид уул уурхайн томоохон ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахдаа олон улсын стандарт, хэм хэмжээг чанд мөрдөхийн зэрэгцээ эрдэс баялгийг түүхийгээр нь экспортлох бус, нэмүү өртөг шингээсэн эцсийн бүтээгдэхүүн боловсруулж гаргах, байгаль орчинд ээлтэй, тогтвортой хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлэх хэтийн зорилго дэвшүүлсэн. Иймд үйлдвэрлэлийг дэмжих чиглэл бүхий хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

#### Стратеги

Уул уурхайн салбарт өнгөрсөн 30 жилд геологи хайгуул, олборлолтын үйл ажиллагаа зонхицж ирсэн. Ирэх 30 жилд энэ салбарт эрдэс баялгийг түүхийгээр экспортлох бус боловсруулж, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, нэмүү өртөг шингээх зарчмыг баримтална.

Газрын тос боловсруулах цогцолборыг барьж ашиглалтад оруулнаар гол нэр төрлийн шатахууны хэрэгцээг Евро 5 стандартад нийцүүлэн дотоодоос бүрэн хангана.

Уул уурхайн мега төслүүдийн хүрээнд үйл ажиллагаа нь нэгэнт эхэлчихсэн Тавантолгойн нүүрсний орд, Оюутолгойн гүний уурхайг оруулсан нь эдгээр ордыг ашиглалтад иж бүрнээр оруулах, хариуцлагатай, дэвшилттэй байдлыг нэмэгдүүлж, боловсруулалтын түвшнийг ахиулахад чиглэсэн зорилт юм. Мөн Дорноговийн цахиурын орд, Цагаансуваргын орд, Хармагтайн орд, Литийн ордыг ашиглалтад оруулах, газрын ховор элементийн хайгуул, судалгааны ажлыг эрчимжүүлэх нь эдийн застийн өсөлтийг хангахад чухал үүрэгтэй.

Уул уурхайн эрдэс, түүхий эдэд түшиглэсэн зэсийн баяжмал, газрын тос боловсруулах, нефть-хими, кокс-хими, металлургийн, нүүрс угаах болон нүүрс-хими, нүүрс-эрчим хүч, метан хийн, ган төмөрлөгийн, жонш баяжуулах, алт цэвэршүүлэх зэрэг өндөр технологийн хүнд үйлдвэрийн цогцолборуудыг барьж байгуулахаар төлөвлөсөн нь эдийн засгийн багтаамж ихтэй, далайцтай ажлууд байх юм. Зөвхөн үйлдвэр, цогцолбор бариад зогсохгүй тэдгээрийг дагасан дэд бүтэц, тээвэр логистикийн сүлжээ тавигдана.

Зураг 12. Газрын тос боловсруулах үйлдвэрийн эдийн засгийн үр ашиг



Монгол Улс хэрэглэж буй шатахуунаа бараг 100 хувь ОХУ-аас импортлон авч байна. Иймд газрын тос боловсруулж, шатахууны импортын хараат байдлыг бууруулах нь стратегийн зорилт юм.



Зураг 13. Нүүрс баяжуулах үйлдвэрийн эдийн засгийн үр ашиг



“

Үйлдвэрт Тавантолгойн ордын коксжих, сул коксжих нүүрсийг баяжуулж, хатуу коксжих нүүрсний баяжмал, хагас зөөлөн коксжих нүүрсний баяжмал, мидлингийг гаргаж, дэлхийн зах зээлд нийлүүлнэ.

”



Зураг 14. Зэс хайлуулах үйлдвэрийн эдийн засгийн үр ашиг



Эх сурвалж: УУХҮЯ, 2021



Эх сурвалж: ХХААХҮЯ, 2022

Бэлчээрийг усжуулах, худажуулах ажлыг үргэлжлүүлэн малын бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлэх, хамгаалах, нөхөн сэргээх, тогтвортой байдлыг хангана. Малын чанар, ашиг шимийг сайжруулж, малын тоог чанарт шилжүүлж малын гений санг хамгаална. Биотехнологийн ололтыг нэвтрүүлэх, эрчимжсэн мал аж ахуйн салбарын хөгжлийг дэмжинэ.



### ЭДИЙН ЗАСГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛҮҮД

## ХӨДӨӨ АЖ АХУЙ, БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР

Хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрийн нөөц бидэнд хангалттай бий. Өнөөдөр хөдөө аж ахуйн нийт бүтээгдэхүүний 80 орчим хувийг мал аж ахуйн салбарт үйлдвэрлэж, экспортын орлогын 6 хувийг бүрдүүлж байна. Монгол мал эх газрын эрс тэс уур амьсгалд байгалийн шалгарал, мал маллагааны олон зууныг дамжиж ирсэн ардын уламжлалын үр дунд байгаль-цаг уурын хатуу ширүүн нөхцөлд дасан зохицож, биологийн онцгой шинжийг хадгалсан онцлогтой. Нэг хүнд ногдох малын тоо болон газар нутгийн хэмжээгээр манай улс дэлхийд тэргүүлдэг. Гэвч малын түүхий эд, хүнсний экспортоор өнөөдрийг хүртэл дэлхийд эрэмбэлэгдэж чадаагүй байна. Иймд хөдөө аж ахуйн салбарыг тэргүүлэх чиглэлийн нэгээр тодорхойлж, байгальд ээлтэй, хариуцлагатай, тогтвортой үйлдвэрлэл бүхий эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлэх зорилт дэвшүүлээд байна.

Манай улс 2018 онд 515.2 мянян тонн мах бэлтгэн, 40 мянян тонн мах боловсруулж экспортолсон. Цаашид улам нэмэгдүүлж, үр ашгийг дээшлүүлэхийн тулд мал сүргийг эрүүлжүүлж, чанар, ашиг шимийг сайжруулах, хүнсний аюулгүй байдлыг хангах, улмаар экспортлогч улсын хорио цээрийн дэглэмд өөрийн орны стандартыг нийцүүлэх, аймаг, бүсийн төвүүдэд буй махны үйлдвэрүүдийг өргөтгөх, шинээр барих, биотехнологийн цех байгуулж, дайвар бүтээгдэхүүнийг ашиглахаар урт хугацааны хөгжлийн бодлогод төлөвлөсөн билээ.

Өнөөдөр бид жил тутам нийт ноолуурынхаа 90 хувьд анхан шатны, 10 хувьд бүрэн боловсруулалт хийж байгаа нь хангалтгүй үзүүлэлт болж байна. 2018 онд 5,410 тонн ноолуур угааж, 571 тонн ноолуур самнасан бол 915.6 мянян ширхэг сүлжмэл хувцас үйлдвэрлэжээ. Гадаад худалдаа эрхлэгчид хаврын улиралд сайн чанарын ноолуурыг бэлэн мөнгөөр худалдан авч, өртөг шингээлгүй экспортолж байгаа бол үйлдвэрлэгчид эргэлтийн хөрөнгө хүрэлцээгүйгээс түүхий эдээ хангалттай нөөцөлж чадахгүй, суурилагдсан хүчин чадлынхаа 40-60 хувийг ашиглаж байна.

Манай улс жилд 14-18 сая ширхэг арьс шир бэлтгэх түүхий эдийн нөөцтэй. Энэ нь арьс ширний салбарыг кластерын зарчмаар хөгжүүлж, цэвэрлэх байгууламж бүхий үйлдвэрийн цогцолбор



Зураг 15. Хөнгөн ба хүнсний үйлдвэрийн салбарын үндсэн үзүүлэлтүүд



#### ХӨНГӨН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТҮҮХИЙ ЭДИЙН НӨӨЦ



Ямааны ноолуур  
**10.0 мянган тонн**



Хонь, тэмээний ноос, хөөвөр  
**41.0 мянган тонн**



Арьс шир  
**17.0 сая ширхэг**

Эх сурвалж: ХХААХУЯ, 2022

байгуулахад хангалттай хүрэлцэх нөөц бөгөөд бүрэн боловсруулж, оёмол сүлжмэл бэлэн бүтээгдэхүүний экспортын хэмжээг нэмэгдүүлэх чиглэлийг баримтална. Гол нь боловсруулах салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг экспортод чиглэсэн, өөрөөр хэлбэл зөвхөн дотооддоо бус бүс нутаг, тив дэлхийн хэмжээний өргөн хүрээтэй зах зээлийн баримжаатайгаар гүн боловсруулалтын технологид суурилсан олон улсын брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэх түвшинд хөгжүүлэх хэтийн зорилт хөгжлийн бодлогод бий.

Газар тариалангийн салбарын гол бэрхшээл бол усалгааны системийн асуудал. Хэдийгээр энэ салбарт оруулах хөрөнгө оруулалт, тариалсан талбайн хэмжээ нэмэгдэж байгаа ч байгаль, цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалан ургацын хэмжээ тогтвортой биш байна. Иймд усалгаатай талбайн хэмжээг нэмэгдүүлэх замаар тус салбарын байгаль цаг уураас хамаарах хамаарлыг бууруулж, ургацын хэмжээг нэмэгдүүлэх чиглэл баримтлахаар тусгасан. Ингэхдээ гадаргын болон бороо, цасны усыг хуримтлуулах, гол мөрний урсцад тохируулга хийх, услалтын систем шинээр барих, сэргээн засварлах, хэмнэлттэй, үр ашигтай технологи нэвтрүүлэх зэргээр хөдөө аж ахуйн салбарын усны хэрэгцээг хангаж, усалгаатай талбайн хэмжээг 100.0 мянган га-д хүргэх зорилт дэвшиүүлж байна. Мөн зөвхөн хөдөө аж ахуй гэлтгүй усны хэрэглээ ихтэй аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарт дээрх арга ажиллагааг нэвтрүүлж хэмнэлттэй, үр ашигтай хэрэглээг хэвшүүлэн усны аюулгүй байдлыг хангах, цэвэрлэх байгууламжтай байх стандарт шаардлагыг мөрдүүлнэ.

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээг хөгжүүлж, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодоос бүрэн хангаж, импортыг орлох болон экспортын баримжаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжинэ.

Зураг 16. Хөнгөн ба хүнсний үйлдвэрийн салбарын үндсэн үзүүлэлтүүд



Эх сурвалж: ХХААХҮЯ, 2022

Тариалангийн тогтвортойт үйлдвэрлэлийн хөгжлийг хангаж, бүтээгдэхүүнийг экспортлох, боловсруулах хүчин чадлыг нэмэгдүүлж, таримлын сэлгээ, тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар салбарын бүтээмж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.

Дөрвөн улирлын эрс тэс уур амьсгалтай манай улсад газар тариалангийн салбарыг техникийн шинэчлэлт, технологийн дэвшилээс ангид авч үзэх боломжгүй. Улирлын хамаарлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадварыг нэмэгдүүлэхийн тулд шинжлэх ухаанч судалгаа, туршилтыг өргөн хүрээнд хийж, өндөр хүчин чадлын техник, ухаалаг удирдлагын систем нэвтрүүлэх шаардлагатай. Түүнчлэн бүс нутаг, хот орчмын онцлогт тохирсон ХАА-г хөгжүүлж, ялангуяа хүнсний үйлдвэрт түүхий эдийн бэлтгэл, ханган нийлүүлэлт, тээвэрлэлт, борлуулалтын бүртгэл, чанарын удирдлага, хяналт, баталгаажуулалтын тогтолцоог нэвтрүүлэн, аюулгүй байдлыг хангах нь боловсруулах аж үйлдвэрийн хөгжлийн голлох хүчин зүйлсийн нэг билээ.

Эдийн засгийн зарим салбаруудад гарах өсөлтийн нөлөөгөөр дотоодын эрэлт нэмэгдэж, бүтээгдэхүүнийхээ дийлэнхийг өөрийн орны зах зээлд нийлүүлдэг ХАА-н салбарт үнэ өсөх, малчид, тариаланчдын орлого нэмэгдэх боломжтой. Эцэст нь 2050 он гэхэд Монгол Улс дэлхийн хамгийн чанартай ноолууран бүтээгдэхүүн, өвөрмөц онцлог бүхий арьс ширэн эдлэл, экологийн цэвэр хүнс үйлдвэрлэгч, оёмол, нэхмэл, хувцас загварын брэндээрээ танигдсан боловсруулах аж үйлдвэрийн орон болохыг зорьж байна.



# МАЛЫН ГАРАЛТАЙ ТҮҮХИЙ ЭД БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР



Боловсруулах үйлдвэрийг хөгжүүлэх зорилтын хүрээнд мал, малын гаралтай түүхий эдийг боловсруулах байгальд ээлтэй цогцолбор байгуулж, хөдөө аж ахуйн гаралтай бараа бүтээгдхүүний экспортыг нэмэгдүүлнэ. Тухайлбал, Дархан цогцолборт арьс шир боловсруулах 13 үйлдвэр, ноос ноолуур угааж самнах хоёр, эсгий хийх нэг үйлдвэр баригдах бол Ховд аймгийн Жаргалант суманд байгуулагдах "Шинэ Ховд үйлдвэр технологийн парк" арьс шир, ноос ноолуур, яс, өлөн гэдэс боловсруулах нийт 16-18 үйлдвэртэй байх юм. Цогцолбор тус бүрд үйлдвэрлэлийн бохир ус цэвэрлэх байгууламж, хаягдал боловсруулж, желатин үйлдвэрлэх үйлдвэрээс гадна судалгаа хөгжил, технологи, инновацын төвүүд ажиллана. Түүнчлэн "Шинэ Ховд үйлдвэр технологийн парк"-ийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын хүрээнд малын гаралтай түүхий эдийн үйлдвэрийн цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажлын гүйцэтгэл 80 хувьтай байна.

- **11 САЯ ш**  
АРЬС ШИР
- **13,000 ТН**  
НООС
- **3,300 ТН**  
НООЛУУР УГААХ, САМНАХ
- **3,400 ТН**  
ХАЯГДАЛ ЯС
- **440,000 ТН**  
ГОГЦОО ӨЛӨН ГЭДЭС

Зураг 17. Малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэр





ЭДИЙН ЗАСГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛҮҮД


## НАЙДВАРТАЙ, ХҮРЭЛЦЭЭТЭЙ ЭРЧИМ ХҮЧ

	<b>САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ (2021)</b>
	Нийт төсөв <b>921</b> тэрбум төгрөг
	Нийт хүчин чадал <b>1,353</b> МВт
	Нийт хэрэглээ <b>8,719.1</b> сая кВт.ц
	Аж үйлдвэрт эзлэх хувь <b>6.9%</b>
	Нийт ажлын байр <b>12,000</b>

Улс орны хөгжлийн зорилгыг хэрэгжүүлэх том төслүүд, бүтээн байгуулалтыг дэмжих зайлшгүй хэрэгцээ бол эрчим хүчиний найдвартай, хангалттай эх үүсвэрийг бий болгох явдал юм. Эрчим хүчиний салбарын стратегийн онцлогийг харгалзан Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэл болгон авч үзэж байна.

Чойбалсангийн дулааны цахилгаан станцын хүчин чадлыг 50 МВт-аар, Улаанбаатар хотын дулааны III цахилгаан станцын өндөр даралтын хэсгийн сууринлагдсан хүчин чадлыг 75 МВт-аар, Амгалангийн дулааны станцыг 50 МВт-ын дулаан, цахилгаан хослон үйлдвэрлэх станц болгон өргөтгөх зэрэг томоохон төслүүдийг төлөвлөж, цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц, шинэ эх үүсвэрийт барьж, цахилгаан эрчим хүчээр дотоодын хэрэгцээг бүрэн хангах, улмаар экспортлох хэмжээнд хүрсэн байх зорилтыг дэвшүүллээ.

Зураг 18. Эрчим хүчиний нийт үйлдвэрлэл, импорт




ДОТООДЫН ЭХ ҮҮСВЭРҮҮДИЙН БҮТЭЦ, ЭЗЛЭХ ХУВЬ

Эх сурвалж: Эрчим хүчиний яам, 2022



Зураг 19. Цахилгаан эрчим хүчиний үйлдвэрлэл, импорт, хэрэглээний таац



Манай улс жилдээ 8.5 тэрбум кВт.ц цахилгаан эрчим хүч хэрэглэдэг бөгөөд үүний 80 хувийг дотоодын эх үүсвэрээс, 20 хувийг импортын цахилгаанаар хангаж байна.

Зураг 20. Дулааны эрчим хүчиний үйлдвэрлэл, импорт, хэрэглээний таац



Импортын цахилгааны ихэнхийг буюу 1.4 тэрбум кВт.ц эрчим хүчийг Оюутолгойн үйлдвэр БНХАУ-аас, Төвийн болон баруун бүсэд жилдээ 300 сая орчим кВт.ц цахилгааныг ОХУ-аас импортолж байна.


Цахилгаан, дулааны эрчим хүчиний үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэн, өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг дотоодоос бүрэн хангах нөхцөлийг бүрдүүлнэ.

Шинэ эх үүсвэрийн тоонд Тавантолгой, Оюутолгойн эрчим хүчийг нийлүүлэх 300 МВт-ын, төвийн бүсийн эрчим хүчиний хэрэглээний өсөлтийг хангах зорилгоор Багануурын 400 МВт-ын цахилгаан станцын зэрэгцээ Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын хүчин чадалтай усан цахилгаан станц, тохируулгын горимд ажиллах 100 МВт-ын цэнэг хураагуурын станц зэргийг нэрлэж болно.

Бүс нутгийн эрчим хүчиний сүлжээг өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугамаар холбож, уул уурхай, хүнд үйлдвэрийн мега төслүүдийн цахилгаан хангамжийг үе шаттайгаар шийдвэрлэж, ухаалаг систем бий болгоно.

Өнөөдрийн байдлаар манай улс цахилгаан хангамжийнхаа 80 хувийг дотооддоо үйлдвэрлэж байгаа ч станцуудын дотоод хэрэгцээ 14.4 хувь, цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний алдагдал 13.9 хувь байгаа нь хөгжингүй орнуудын жишгээс 1.3-1.7 дахин өндөр байна. Энэ алдагдлыг орчин үеийн технологи, шийдлээр бууруулж, босоо болон хөндлөн гол тэнхлэгийн цахилгаан дамжуулах агаарын шугамыг өргөтгөн шинэчилснээр эрчим хүчиний нэгдсэн системийг дэвшилтэт технологид суурилсан дэд бүтэц бүхий ухаалаг систем болгон хөгжүүлэх зорилтыг дэвшүүлсэн. Энэ хүрээнд Чойр-Сайншанд-Замын-Үүдийн 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц, Багануур-Улаанбаатар дэд станцыг холбох 220 кВ-ын 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцуудын өргөтгөл, Багануур-Чойрын 220 кВ-ын 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц, Багануур-Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн 220 кВ-ын 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц, Эрдэнэбүрэн-Улиастайн 220 кВ-ын 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барина.

Зураг 21. Цахилгаан эрчим хүчиний үйлдвэрлэл, импорт, хэрэглээний тооц




Эх сурвалж: Эрчим хүчиний яам, 2022

Төвлөрсөн хот, сум, суурин газарт дулааны эх үүсвэр шинээр барих, өргөтгөх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж, дулаан хангамжийн чанар хүртээмж, ард иргэдийн ая тухтай амьдрах нөхцөлийг сайжруулна. (Завхан, Говь-Алтай, Баянхонгор, Өвөрхангай, Архангай, Дундговь, Говьсүмбэр, Төв, Сүхбаатар, Хэнтий аймагт дулааны станц барина.)

Дотооддоо үйлдвэрлэж буй нийт цахилгаан эрчим хүчнийхээ  
ердөө зургаан хувийг нар, салхины эх үүсвэрээр, нэг хувийг усан  
цахилгаан станцаар үйлдвэрлэж байна. Ирэх 30 жилд сэргээгдэх  
эрчим хүчний суурилагдсан хүчин чадлыг 30 хувьд хүргэхийн  
зэрэгцээ орон нутгийн дулаан хангамжид ашиглаж эхэлнэ.  
Түүнчлэн эх үүсвэрийн чадлын баланстай уялдуулан нар, салхи,  
усаар тогтохгүй биомасс, шингэн болон хийн түлш, газрын  
гүний дулаан, түлшний элемент болон бусад шинэ эх үүсвэрээр  
эрчим хүч үйлдвэрлэх эрэл судалгааг эрчимжүүлж, ашиглалтад  
нэвтрүүлэх зэрэг зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлэх юм.  
Эдгээр судалгаа шинжилгээ болон эрчим хүчний хөгжлийг хангах  
олон талт хамтын ажиллагааг бүс нутгийн хэмжээнд өрнүүлж,  
Зүүн хойд Азийн орнуудтай хамтран Азийн эрчим хүчний  
нэгдсэн сүлжээний санаачилгыг хэрэгжүүлэх, улмаар инновац,  
дэвшилтэт техник, ухаалаг технологийг нэвтрүүлж, санхүүгийн  
бие даасан үр ашиг, хэмнэлттэй эрчим хүчний тогтолцоог  
бүрдүүлэх нь хөгжлийн бодлогын нэгэн зорилт байх юм.

Сэргээгдэх эрчим хүчний  
үйлдвэрлэлийг зохицой  
харьцаагаар хөгжүүлж,  
хүлэмжийн хийн ялгаруулалтыг  
бууруулах ногоон  
үйлдвэрлэлийн төслүүдийг  
хэрэгжүүлнэ.

Зураг 22. Цахилгаан дамжуулах агаарын шугамын төслүүд



Эх сурвалж: Эрчим хүчний яам, 2022

## ЭРДЭНЭБҮРЭНГИЙН УСАН ЦАХИЛГААН СТАНЦЫН ТӨСӨЛ



Өнөөдөр манай улс Баруун бүсийнхээ эрчим хүчний хэрэглээний 74 хувийг импортоор хангаж байна. Импортын эрчим хүчний үнэ бидний дотооддоо үйлдвэрлэж буйгаас 5-6 дахин өндөр үнэтэй байна. Тус бүс нутгийн эрчим хүчний хэрэгцээг хангах, горим тохируулгын үүрэг гүйцэтгэх, импортыг халах 90 МВт-ын хүчин чадалтай усан цахилгаан станцыг Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын нутагт, Ховд гол дээрх Шижигтийн хавцалд барьж ашиглалтад оруулна.

Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц ажиллаж эхэлснээр импортын эрчим хүчинд жил бүр зарцуулдаг 17.5 тэрбум төгрөгийг хэмнэхийн зэрэгцээ Баруун бүс, Алтай-Улиастайн эрчим хүчний системийн үнийн зөрүүд улсын төсвөөс төлж буй төлбөрийн зардлыг арилгана. Станц жилд 366 сая кВт.ц цахилгаан эрчим хүч үйлдвэрлэж, баруун таван аймгийн 253.3 сая кВт.ц хэрэглээ болон тус бүсийн цаашид өсөн нэмэгдэх хэрэгцээг бүрэн хангана.

Зураг 23. "Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц" төсөл

Жилд дунджаар **366 сая кВт.цаг** цахилгаан эрчим хүч үйлдвэрлэнэ.



**1.3 сая тонн** хүлэмжийн хийг бууруулна.

**17.5 тэрбум төгрөг**

төсвийн хэмнэлт

**253.3 сая кВт.ц**

баруун таван аймгийн хэрэглээ болон тус бүс нутгийн өсөн нэмэгдэх цахилгаан эрчим хүчний хэрэгцээг хангана

**52,000**

айл өрх

Эх сурвалж: Эрчим хүчиний яам, 2022

ОХУ, БНХАУ-аас авч буй импортын эрчим хүчний төлбөр болох 17.5 тэрбум төгрөгийг хэмнэнэ. Дотоодын эрчим хүчний эх үүсвэр бий болсноор Баруун бүс, Алтай-Улиастайн эрчим хүчний систем улсын төсвөөс эрчим хүчний үнийн зөрүүд татаас авдаггүй болно. Жилд 366 сая кВт.ц цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх ба баруун таван аймгийн 253.3 сая кВт.ц хэрэглээ болон тус бүс нутгийн өсөн нэмэгдэх цахилгаан эрчим хүчний хэрэгцээг бүрэн хангана. Нийт 52,000 ахуйн хэрэглэгчдийг хангах шинэ эх үүсвэр бий болж, баруун 5 аймгийн 4,430 аж ахуйн нэгж, 5,400 орон сууц, 36,413 гэр хорооллын хэрэглэгчийг дотоодын цахилгаан эрчим хүчээр бүрэн хангана.



# ТАВАНТОЛГОЙН ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦЫН ТӨСӨЛ



Тавантолгойн нүүрсний ордыг түшиглэн 450 МВт-ын суурилагдсан хүчин чадалтай дулааны цахилгаан станц, хоёр хэлхээ бүхий 220 кВ-ын 141 км цахилгаан дамжуулах агаарын шугам, 220 кВ-ын дэд станцын хамт барьж ашиглалтад оруулна. Тус станц жилд 3,150 сая кВт.ц цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх ба Оюутолгойн өсөн нэмэгдэх 2,242.5 сая кВт.ц хэрэглээ болон Тавантолгойн орд газрууд, бусад стратегийн ач холбогдол бүхий өмнөд бүсийн уул уурхайн төслүүдийн цахилгаан эрчим хүчиний хэрэглээг бүрэн хангана.

Оюутолгойн БНХАУ-аас авч байгаа 110-130 сая ам.долларын импортын эрчим хүчийг орлох эх үүсвэр бий болох ба үүний зэрэгцээ жил бүр улсын төсөвт 34.0 сая ам.долларын татварын орлого бүрдүүлэх юм. Өмнийн.govийн уул уурхайн эрчим хүчиний хэрэглээг найдвартай эрчим хүчиний эх үүсвэрээс хангана.

Тавантолгойн ДЦС өмнийн.govийн уул уурхайн эрчим хүчиний хэрэглээг найдвартай эх үүсвэрээр хангаж, коксжих нүүрсний олборлолтын үед хаягдаж байгаа бага илчлэгтэй эрчим хүчиний нүүрсийг эдийн засгийн эргэлтэд оруулах, цахилгаан дамжуулах агаарын шугамын алдагдлыг бууруулж, тус бус нутгийн уул уурхай, боловсруулах аж үйлдвэрийн төслүүдийн эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

Зураг 24. Тавантолгойн дулааны цахилгаан станцын төсөл



**3,150 сая**  
кВт/цаг жил



**130 сая \$**  
импорт орлоно



**300**  
ажлын байр

Эх сурвалж: Эрчим хүчиний яам, 2022



Азийн авто замын сүлжээнд Монгол Улс нэгдэн орох бодлогын дагуу 2004 оны дөрөвдүгээр сард "Азийн авто замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр"-т АН-3, АН-4, АН-32 гэсэн чиглэлээр 4,286.0 км авто замаар нэгдэн орохоор тусгагдсаныг УИХ 2005 онд соёрхон баталсан.




## ЭДИЙН ЗАСГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛҮҮД ТЭЭВЭР ЛОГИСТИК

Эдийн засгийн нийлүүлэлтэд хүчтэй нөлөөлж, урт хугацааны ерсөлдөх чадвар, бүтээмжийг дэмждэг салбар бол зам тээвэр, логистикийн салбар билээ. Экспортын бүтээгдэхүүнээ хямд өргтөөр, хүйтэн хэлхээний системээр байгаль экологид хор хөнөөлгүй, шуурхай тээвэрлэх үндэсний тээвэр, логистик, хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх зэрэг олон асуудлыг шийдэхэд чиглэсэн бодлогын зорилт дэвшүүлсэн.

Өнөөдрийн байдлаар манай улс гадаад тээвэрлэлтийн хамгийн өндөр зардалтай орнуудын тоонд орж байна. Энэ нь хоёр их гүрний дунд оршиж, хөрш орнуудын дамжин өнгөрөх тээврийн үнэ тарифаас хамааралтай байдгаас үүдэлтэй. Тиймээс тээврийн зардлыг бууруулж, үндэсний бараа бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхийн тулд дэд бүтцээ хөгжүүлэхээс өөр гарц байхгүй буюу дээр дурдсан тээвэр логистикийн хөгжлийн дэмжих төслүүд төлөвлөсний дагуу бүрэн гүйцэт хэрэгжүүлэхээс өөр аргагүй юм. Тэгээд ч Тажикистаны Душанбе хотноо 2021 оны есдүгээр сард болсон Шанхайн хамтын ажиллагааны байгууллагуудын гишүүн орнуудын уулзалтын үеэр Монгол Улс Ази, Европыг холбосон худалдаа, тээвэр логистикийн

Зураг 25. Азийн авто замын сүлжээ



Эх сурвалж: UNITED NATIONS ESCAP, 2022



сүлжээ, ачаа тээврийн урсгал, үйлчилгээг зангиdsan “Транзит улс” болох зорилтоо нэгэнт зарласан юм.

Бодлогын эхний үе шатанд олон улсын гурав, бус нутгийн зургаан логистикийн сүлжээг байгуулж, хөрш орнуудтай холбох, хоёр дахь үе шатанд орон нутгийн 33 логистикийн сүлжээ байгуулж, олон улсын болон бус нутгийн сүлжээнд холбох, гурав дахь үе шатанд хэрэглэгч бүрд хүрсэн орчин үеийн ухаалаг тээвэр логистикийн сүлжээг нэвтрүүлэх гэсэн эрэмбээр үндэсний тээвэр логистикийн тогтолцоог бүрдүүлэхээр төлөвлөж байна. Замын-Үүд, Алтанбулаг, Цагааннуурын чөлөөт бус, Хөшигийн хөндий, Говьсүмбэрийн Баянтал дахь эдийн засгийн чөлөөт бүсүүдийг ашиглалтад оруулж, хилийн Хавирга, Гашуунсухайт, Шивээхүрэн, Булган, Боршоо, Арцсуурь, Бага Илэнхи боомтуудын нэвтрэх чадварыг үе шаттайгаар нэмэгдүүлэх, судалгаа тооцоотой зорилтуудыг хэрэгжүүлнэ.

Мөн стратегийн орд газруудыг хилийн боомттой холбосон буюу Тавантолгой-Гашуунсухайт, Зүүнбаян-Ханги Мандал, Сайншанд-Баруун-Урт-Хөөт, Нарийн сухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр замуудыг ашиглалтад оруулна. Ингэснээр транзит болон экспортын ачааг Хятадын нутаг, түүний далайн боомт мөн гуравдагч орны зах зээл рүү тээвэрлэх боломжтой. Төмөр замын барилгын ажил болон ашиглалтын үйл ажиллагаатай холбоотойгоор орон нутагт

Зураг 26. Транс-Азиийн төмөр замын сүлжээ



Эх сурвалж: UNITED NATIONS ESCAP, 2022

#### Транзит тээвэр

Монгол Улсын төмөр замын транзит ачааны ихэнх хувийг ОХУ-аас БНХАУ руу мод тээвэрлэн, дамжин өнгөрөх тээвэр эзэлж байна. Эсрэг чиглэлд буюу БНХАУ-аас ОХУ руу чиглэсэн ачаа тээврийн хэмжээ харьцангуй бага байна.

#### Ачаа тээвэр

Төмөр замын экспортын ачаа тээвэр 2021 онд ойролцоогоор 10.9 сая тонн, импортын ачаа тээвэр 3.3 сая тонн байна. Авто замын ачаа тээврийн хэмжээ төмөр замынхтай ижил харьцаатай гэж үзвэл төмөр зам болон авто замаар хийсэн тээврийн экспорт, импортын болон транзит ачааны хэмжээ тус тус 26.3 сая тонн, 4.36 сая тонн болж байна.

шинээр түр болон байнгын ажлын байр олноор бий болж, иргэд мэргэжилтэй, ажилтай, орлоготой болох нөхцөл бүрдэнэ.


Монгол Улсын нутаг дэвсгэрээр тээвэрлэх авто замын ачаа тээврийн одоо мөрдөж байгаа тариф тонн тутам 32 ам.доллароос 8.0 ам.доллар болж, 75 хувиар буурна. Нүүрс тээврийн тарифт тонн тутмаас 24 ам.долларын хэмнэлт гарах бөгөөд жилд 430 сая ам.доллар болж, манай улс нүүрсний экспорт тоос жил тутам 2.3 тэрбум ам.доллар, төмөр замын тээврээс 227 сая ам.долларын орлогыг бүрдүүлэх боломж бий болно. Жилдээ 30 сая тонн ашигт малтмал болон бусад ачааг тээвэрлэн экспортолно.

Дэлхийн эдийн засгийн форумаас гаргадаг Аялал жуулчлалын өрсөлдөх чадварын үзүүлэлт (индекс)-ээр Монгол Улсын олон улсын нислэгийн зах зээлд танигдах нээлттэй байдлын үзүүлэлт доогуур, агаарын тээврийн дэд бүтцийн хөгжил хангалтгүй байгаагаас манай улсаас хөөрөх, буух нислэгийн тоо цөөн байна.

Монгол Улс аялал жуулчлалын өрсөлдөх чадварын тайланд “олон улсад нээлттэй байдал”-ын үзүүлэлтээр хамгийн бага оноо авсан орнуудын нэг буюу 140 орноос 128-д эрэмбэлэгдсэн. Монгол Улсад ирж буй нийт жуулчдын 44.6 хувь нь Чингис хаан олон улсын нисэх буудлаар дамжиж ирдэг. Монгол Улс руу аялах зардал харьцангуй өндөр хэвээр байна.

Иймд агаарын тээврийн либералчлалыг хэрэгжүүлж, нислэгийн чиглэл, тоог нэмэгдүүлэн авиа компанийн өрсөлдөөнийг дэмжих

Зураг 27. Агаарын замын сүлжээ



Эх сурвалж: ЗТХЯ, 2022



зорилт дэвшиүүлсэн. Энэ хүрээнд Зам, тээврийн хөгжлийн сайд, БОАЖ-ын Сайдын хамтарсан “Зөвлөл” байгуулан аялал жуулчлал, агаарын тээврийн салбарын уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулах чиглэлээр хамтран ажиллаж байна. Агаарын тээврийг үе шаттай либералчлах, зах зээлд нийлүүлэх суудлын тоо, нислэгийн багтаамжийг нэмэгдүүлэх төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Мөн Агаарын харилцааг өргөжүүлж, агаарын тээврийг либералчлах ажлын хүрээнд: АНУ, БНУЗУ, Унгар, Бүгд Найрамдах Латви Улс, Словени, Итали Улс, Грек Улсуудтай тус тус агаарын харилцааны хэлэлцээр байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна. Иргэний нисэхийн болон ерөнхий зориулалтын нисэхийн дэд бүтцийг хөгжүүлэх, холимог тээврийн салбарт инновац, дэвшилтэт техник технологи, цахим шилжилтийг нэвтрүүлэхийн зэрэгцээ аюулгүй байдал, найдвартай ажиллагааг хангах удирдлага менежментийн тогтолцоог нэвтрүүлж, нисэх буудал, зорчигч үйлчилгээний цогцолборуудыг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартад нийцүүлэн байгуулах чиглэлээр Олон улсын нисэх буудлын сайн туршлагыг судалж, нэвтрүүлэн, хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

Зураг 28. Олон улсын агаарын тээврийн нэвтрэх терминалын хүчин чадал



БНСУ-ын Инчеоны нисэх буудал

Инчеоны нисэх буудалд 90 авиа компани 188 агаарын замтай бөгөөд **4 саянт ачаа тээвэрлэх хүчин чадалтай**.

Инчеоны логистикийн паркт 35 компани логистикийн байгууламж ажиллуулдаг. Нийт 300 орчим компани үйл ажиллагаа явуулж байна. **БНСУ-ын импорт, экспортын 30 хувийг эзэлдэг**.

Логистикийн паркийн хүчин чадлын ашиглалт 91-99 хувьтай байна.



Японы Нарита нисэх буудал

Нарита нисэх буудлын карго ачаа тээвэрлэх хүчин **чадал жилд 2,4 сая. тн байна**.

Тус нисэх буудал нь **Япон улсын карго ачааны 60 хувийг** дангаараа гүйцэтгэдэг бөгөөд 40 орчим компани 42 байршилд олон улсын логистикийн байгууламж ажиллуулж байна.



Сингапурын Чанги нисэх буудал

Сингапурын гааль, эдийн засгийн хөгжлийн агентлагуудын дэмжлэгтэйгээр Сингапурын Чөлөөт Худалдааны бусийн статустай байгуулгасан анхны логистикийн парк юм.

Чанги нисэх онгоцны буудал нь өнөөгийн байдлаар нийт **2 сая.тн карго ачаа тээвэрлэж** байна. Тус нисэх буудалд тээврийн 126 компани хамтын ажиллагаатай бөгөөд дэлхийн **99 орны 411 хотийн холбогдсон** байна.


Чанги нисэх онгоцны буудалд **90 секунд тутамд онгоц хөөрч, бууж байдаг** ба долоо хоногт 7,450 нислэг хийж байна.

## ТӨМӨР ЗАМЫН ТӨСӨЛ



Манай улс 2019–2021 онд өөрсдийн хүч хөрөнгөөр Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 416.1 км төмөр замын бүтээн байгуулалтыг амжилттай хийсэн. Удахгүй зүүн босоо чиглэлийн буюу Дорнод аймгийн Чойбалсан хотоос Эрээнцав чиглэлийн 237 км төмөр замыг сэргээн шинэчилж, Чойбалсан-Хөөт чиглэлд шинээр төмөр зам барих ажлуудыг эхлүүлэхээр бэлтгэж байна. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын голын даац нь 25 тонн, царигийн хэмжээ 1,520 мм байна. Уг төмөр замаар жилд 15 сая тонн орчим уул уурхайн бүтээгдэхүүнийг бага зардлаар, богино хугацаанд тээвэрлэж, эскортлох боломж бурдэнэ. Төмөр замын төслүүд уул уурхайн бүтээгдэхүүний экспортын өртөг зардлыг бууруулаад зогсохгүй цаг хугацааг хэмнэх, тээвэрлэлтийн хэмжээг нэмэгдүүлэх олон талын ач холбогдолтой. Мөн Монгол Улсаар дамжин өнгөрөх чингэлэг тээврийн урсгалыг нэмэгдүүлэх агаад Зүүн, Зүүн Өмнөд Азийн төмөр замын сүлжээнд холбогдоноор манай улсын экспортын түүхий эд, эрдэс баялагийн бүтээгдэхүүнүүд Хятадаар дамжин гуравдагч Япон, Өмнөд Солонгос, Энэтхэг, Вьетнам зэрэг орон руу хүрэх, улмаар олон боомтоор далайд гарах боломжтой юм.

Зураг 29. "Тавантолгой-Гашуунсуухайт, Тавантолгой-Зүүнбаян төмөр зам" төсөл



Эх сурвалж: ЗТХЯ, 2022

Транзит болон экспортын ачааг Хятадын нутаг, түүний далайн боомт мөн гуравдагч орны зах зээл рүү тээвэрлэх боломжтой. Төмөр замын барилгын ажил болон ашиглалтын үйл ажиллагаатай холбогдон өмнөд бусийн орон нутагт шинээр түр болон 3,200 орчим байнгын ажлын байр бий болж, иргэд ажилтай, орлоготой болох нөхцөл бурдэнэ.




# БОГДХАН ТӨМӨР ЗАМЫН ТӨСӨЛ



Улаанбаатар болон нийслэлийн шинэ суурьшлын бүс чиглэлийн хурдны төмөр зам, Аршаант-Мааньт чиглэлийн 135.8 км Богдхан төмөр зам болон баруун босоо чиглэлийн буюу Арцсуурь-Шивээхүрэнгийн төмөр замыг тус тус барина. Богдхан төмөр замын төсөл нь Монгол-Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэгийн гол замын Мандал өртөөнөөс салаалан Богдхан уулын урдуур тойрч, Багахангай өртөөнд холбогдох чиглэлтэй бөгөөд техник, эдийн застийн үндэслэлийг 2021 оны III улиралд хийж, 2022 оны нэгдүгээр сард Засгийн газар дэмжсэн. Энэ төсөл хэрэгжсэнээр төмөр замын дамжин өнгөрөх болон бусад экспорт, импортын ачаа тээврийг Богдхан уулын урдуур тойруулж, нийслэл дундуур өнгөрүүлэлгүй тээвэрлэнэ. Төмөр замын одоогийн шугамыг зорчигчийн галт тэрэг аялуулах, хот дүүргийн нийтийн зорчигч тээвэр зэрэгт ашиглах боломж бүрдэнэ. Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулж, зорчигч тээврийн нөхцөлийг сайжруулж, дуу чимээний бохирдол багасаж, нийслэлд нийтийн тээврийн шинэ урсгал бий болж, зорчигч тээврийн нэгдсэн терминал байгуулагдах бөгөөд төмөр замын ачааны терминал, салаа замууд болон барилга байгууламжийн дагуух газарт дахин төлөвлөлт хийгдэнэ. Богдхан төмөр зам төслийн хүрээнд Монгол Улсад анх удаа 16.6 км урттай хоёр туннелийг үндэсний компаниудын хүчээр бүтээн байгуулна.

Зураг 30. “Богдхан төмөр зам” төсөл



Эх сурвалж: ЗТХЯ, 2022



### ЭДИЙН ЗАСГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛҮҮД

## ҮНДЭСНИЙ ОНЦЛОГТОЙ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

	<b>САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ (2021)</b>
	ДНБ-д ээлэх хувь <b>6.5%</b>
	Төсөвт төвлөрүүлж буй орлого (2019) <b>607 сая \$</b>
	Жуулчдын тоо <b>570,000</b>
	Түр оператор <b>270</b>
	Нийт ажлын байр <b>82,000</b>

Бид нүүдлийн соёл, байгаль, хүн, мал аж ахуйн өвөрмөц харилцан шүтэлцээт иргэншилийг хадгалж ирсэн үндэстэн. Дэлхийн түүхэнд тодрон гарч, Ази-Европын хооронд урьд нь байгаагүй соёл, худалдааны шинэ харилцааг үүсгэж байсан өвөг дээдсийн арвин баялаг түүх бидэнд бий. Унаган төрхөөр нь хадгалсан эртний сайхан нутаг, үзэсгэлэнт байгаль, уул ус бидэнд байна. Энэ бүхэн үнэлж баршгүй их өв, бидний бахархал, үнэт зүйл юм. Байгаль, түүх, уламжлал соёлынхоо энэ их өвийг сурталчлан таниулж чадсанаар аялал жуулчлалын өлгий нутаг болох боломж бий.

Үндэсний онцлог бүхий төрөлжсөн аялал жуулчлалыг эдийн засгийн тэргүүлэх чиглэлийн нэг хэмээн тодорхойлж, урт хугацааны хөгжлийн бодлогодоо тусган хэрэгжих боломжтой, бодит үр дүн бүхий зорилтуудыг хэрэгжүүлснээр “тогтвортой хөгжлийн салбар” болж, 2050 он гэхэд жилд 6.0 сая хүртэл жуулчин хүлээн авах чадавх суурилагдсан байхаар тооцож байна. Үүний тулд гадаад сурталчилгаа, маркетингийн үйл ажиллагааг эрчимжүүлж, олон

Зураг 31. Аялал жуулчлалын өрсөлдөх чадварын үзүүлэлт





Зураг 32. Бус нутгийн аялал жуулчлалын талаарх зарим мэдээлэл (2019)



улсын аялал жуулчлалын сүлжээнд нэгдэн, олон улсын жишигт нийцсэн үйлчилгээний стандартуудыг нэвтрүүлэх зэрэг олон үйл ажиллагааг үе шаттай хэрэгжүүлнэ. Эх орноо гадаадад сурталчлах цахим платформ бүтээх, олон улсад Монголын аялал жуулчлалын төвийг байгуулах, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг салбарын хөгжилд чиглүүлэх зэрэг бодлогын зохицуулалт хийнэ. Түүнчлэн аймгуудын нисэх буудлыг олон улсын түвшинд хүргэн хөгжүүлж, бус нутаг бие даан гадаадын жуулчид хүлээж авах боломжийг бүрдүүлж, орон нутаг дахь аялал жуулчлалын цогцолборын чиглэлд хийх нислэгийн тоог нэмэх зэрэг шат дараатай зорилтыг тусгасан.

Аялал жуулчлалын дэд бүтцийг сайжруулах, өргөжүүлэх чиглэлээр авто замын ажлууд хийгдэж, 100 км тутамд нэгдсэн стандарт бүхий түр буудаллах зогсоол барьж, гадаадын жуулчдад үйлчлэх бололцоог бүрдүүлэхийн дээр зарим тусгай хамгаалалттай газар нутгийг байгальд ээлтэй эко аялал жуулчлалын зориулалтаар хөгжүүлнэ. Ийм газар нутагт ихэвчлэн байгалийн өвөрмөц тогтоцтой, үзэсгэлэнт түүхийн дурсгалт газрууд хамаардаг тул аялал жуулчлалын зорилгоор ашиглах боломжтой юм. Түүнчлэн шашин, соёл спорта, адал явдалт аялал зэрэг улирлын хамаарал багатай төрлүүдийг дэмжин хөгжүүлснээр тасралтгүй ажиллах боломж хангагдаж, тогтвортой хөгжлийн салбар болох нь гарцаагүй.

Эх сурвалж: Дэлхийн аялал жуулчлалын байгууллага, 2020

Аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээ, чанар стандартыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн дотоод, гадаадын жуулчдын тоог нэмэгдүүлнэ.



### ЭДИЙН ЗАСГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛҮҮД

## БҮТЭЭЛЧ ҮЙЛДВЭРЛЭЛ, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ

	<b>СОЁЛЫН БҮТЭЭЛЧ ҮЙЛДВЭРЛЭЛ БА САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ (2021)</b>
	ДНБ-д эзлэх хувь <b>1.1</b> хувь
	Борлуулалтын орлого <b>1,302.5</b> тэрбум төгрөгөөр
	Нийт ажлын байр <b>33,931</b>
	Бүртгэлтэй аж ахуйн нэгж <b>11,697</b>

Эх сурвалж: Соёлын яам, 2022

Олон улсад өрсөлдөх чадвар бүхий соёл урлагийн чадварлаг хүний нөөцийг бэлтгэж, ажлын байраар хангах тогтолцоог сэргээнэ.

Дэлхий ертөнц хувьсан өөрчлөгдөж байна. Даяаршлын үйл явц улс хооронд шинэ санаа, шинэ мэдлэгийн урсгалыг үүсгэж, хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлсийн хандлагыг тогтоосон бол дангааршлын үйл явц үндэсний онцлог, уламжлалт мэдлэг, зан заншлын соёл болон танигдахуйн давуу талуудыг товойлгож, бидний амьдралд олон талаар нөлөөлөх болсон. Гадаад, дотоод орчны ийм нөлөөн дор Монгол Улс хөгжлийнхөө шинэ орон зайг тодорхойлох, ард түмний сайн сайхныг хангахын тулд юуны өмнө хязгаарлагдмал нөөц боломждоо нийцүүлсэн эдийн засаг, бизнесийн шинэ салбаруудыг хөгжүүлэх нь чухал юм.

Хүний бүтээлч чанар, шинэ санаа, оюуны чадвар, мэдлэгт тулгуурласан эдийн засгийн салбар эдүгээ дэлхий дахинд ихээхэн идэвхжиж, соёл, мэдээллийн технологиор дамжсан амьдралын шинэ хэв маяг нийгмийн хөгжлийн чиг хандлагыг тогтоож байна. Энэ нь оюуны чансаа, авьяас чадвар, сурц болон дасан зохицох чадавхаараа ялгардаг монголчуудын хувьд энэхүү онцлог, шинэлэг салбарт өндөр бүтээмжтэй, үр ашигтай ажиллах боломжийг бий болгож байна. Тийм ч учраас урт хугацааны хөгжлийн бодлогодоо бүтээлч эдийн засгийн салбарыг тэргүүлэх чиглэлээр тодорхойлсон нь “Алсын хараа-2050”-ийн ялгарах бас нэг онцлог, шинэ дэвшил гэж хэлж болно.

Нэн тэргүүнд соёл урлаг, кино урлаг, дуу хөгжим, дизайн, архитектурын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх буюу авьяас чадварыг эдийн засгийн эргэлтэд оруулах бодлогын суурийг тавина. Энэ хүрээнд бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих эрх зүйн орчин, дэд бүтцийг бүрдүүлж, өндөр хөгжилтэй орнуудад мэргэжилтэн бэлтгэж, дэлхийн зах зээлтэй холбох бөгөөд үйлдвэрлэлийн дотоод төрөлжилтийг бодлогоор хангаж, улмаар гадаад зах зээлд байр сууриа олсон үндэсний соёлын брэндүүдийг бий болгох юм. Энхүү шат дараатай үйл ажиллагааны үр дүнд 2050 он гэхэд бүтээлч аж үйлдвэрлэл ДНБ-ний тодорхой хувийг бүрдүүлдэг томоохон салбар болж хөгжих билээ.

Бүтээлч үйлдвэрлэлийг идэвхжүүлж буй гол хүчин зүйл нь аж үйлдвэрийн IV хувьсгал бөгөөд харин аж үйлдвэрийн хувьсгалыг нөхцөлдүүлж буй үндэс нь их өгөгдөл болон мэдээллийн



Зураг 33. Соёлын бүтээлч үйлдвэрлэл дэлхийд



технологи, хиймэл оюун ухаанд суурилсан автоматжуулалт, робот техник юм. Тодруулбал, үйлдвэрлэл, бизнес, эдийн засаг бүхэлдээ ухаалаг технологид шилжиж зардлыг бууруулан шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд түргэн гаргах, хэрэглэгчид өөрт шаардлагатай бүтээгдэхүүнийг өөрөө зохион бүтээх хүртэл боломжийг бүрдүүлж, байгалийн нөөц болон эрчим хүчний хэрэглээг илүү үр ашигтай болгож байна.

Дэлхийн эдийн засгийн форумыг санаачлагч Клаус Шваб 2016 онд хэвлүүлсэн Аж үйлдвэрийн IV хувьстгал номдоо үйл явц нэгэнт өрнөж эхэлснийг дурдаад, хувьстгал зөвхөн үйлдвэрлэх арга технологи, ажиллах хүчний бүтэц, хөдөлмөрийн хуваарилалт, улс орны эдийн засгийн өсөлт, өрсөлдөх чадварыг өөрчлөөд зогсохгүй нийгмийн хэв шинж, уламжлал заншил, хүн хоорондын харилцаанд хүртэл нөлөөлөх асар өргөн цар хүрээтэй үйл явдал болно гэж бичсэн байdag. Хөгжингүй орнуудад аж үйлдвэрийн шинэ хувьстгалын нөлөөгөөр үйлдвэрлэлд их өгөгдөл, ухаалаг технологи, алсын зайн хяналт, удирдлага бүхий олон үйлдэлт техник ашиглах хандлага хүчтэй болж байна. Дижитал шилжилт цаашид улам өрнөлтэй, хурдтай явагдаж, хөдөлмөрийн зах зээл дэх ажиллах хүчний эрэлтийг бууруулах, зарим төрлийн ажил мэргэжлийг устган үгүй болгох, шинэ мэргэжил үүсгэх болон зарим талаар үйлдвэрлэл, бизнест хүний оролцоог багасгах, ажлын байр буурах зэрэг олон талын нөлөөг үзүүлэхээр байна.

Эх сурвалж: Соёлын яам, 2022

Үндэсний агуулгатай инновац шингэсн соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжиж, соёлын аялал жуулчлал, кино урлаг, сонгодог урлагийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг олшруулан, эдийн засгийн эргэлтэд оруулна.

Зураг 34. Соёлын бүтээлч үйлдвэрлэл ба хөгжлийн бодлого, баримтлах зарчим

<b>1. ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ</b>							
● Оюуны өмчийг хэрэглэнд оруулах	● Тогтвортой бизнес, урлагийн байгууллагыг бий болгохын тулд соёлын бүтээлч үйлдвэрлэгчдийг бойжуулж, уран бүтээлчдээ дэмжих	● Дэлхийн түвшний дэд бүтцийг бий болгох	● Салбар бүрийн онцлогт тулгуурлан соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх, үйлдвэрлэлэх, түгээх үе шатуудад тэтгэлэгт хөтөлбөр бий болгох	● Эрдэмтэд, судлаачдын мэдлэг, мэдээллийг соёлын бүтээлч үйлдвэрлэгчдэд таниулах, сурталчлах, өвлүүлэх	● Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн "Нэг салбар" систем, соёлын боловсрол, бүртгэл мэдээллийн "Нэг соёл" системүүдийг хөгжүүлэх	● Монгол Улсын СБҮ-ийн өргөн хүрээний брэндийг боловсруулах, голлох зах зээлүүдэд Монголын бүтээлч зэйн засгийг таниулах брэндийн стори-ийг хөгжүүлэх	● Аяяас, инновац, бизнесийг холбосон экосистемийг хөгжүүлэх
● Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн 12 салбарыг дэмжсэн эрх зүйн орчныг бүрдүүлэх	● Томоохон хэмжээний бүтээл хийх боломжтой кино, ТВ студи, байгууламж, СБҮ-ийн кластер, зорилтот дэд бүтэц бий болгох						● Хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах

#### БАРИМТЛАХ ЗАРЧИМ

#### БАЙГАЛЬД ЭЭЛТЭЙ ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтод тулгуурласан байгаль орчинд ээлтэй бодлого хэрэгжүүлэх.

#### ХҮРТЭЭМЖТЭЙ ЕСӨЛТ

Нүүдлийн соёл иргэншилд тулгуурласан бух хүнд тэгш хүртээмжтэй бүтээлч эдийн засгийг цогцлоох.

#### СУДАЛГАА, БАРИМТ, ТҮНШЛЭЛ

Судалгаа, шинжилгээ, түншлэл дээр тулгуурласан соёлын бүтээлч үйлдвэрлэлийн хөгжлийн бодлогыг бий болгох.


Эх сурвалж: Соёлын яам, 2022

Аж үйлдвэрийн хувьсгалын нөлөө, дэлхий дахинь үйлдвэрлэл, эдийн засгийн чиг хандлагыг харгалзан Монгол Улс мэдээллийн технологийг тэргүүлэх чиглэл гэж үзэн, өндөр бүтээмжтэй салбар болгон хөгжүүлэх бодлогыг тодорхойлсон. 2050 он хүртэл баримтлах хөгжлийн бодлогод мэдээллийн технологийг экспортод чиглүүлэн хөгжүүлэх институцийн тогтолцоог бүрдүүлэхээр зааж, зөөлөн болон хатуу дэд бүтцийг бий болгон, судалгаа, шинжилгээг өргөжүүлж, инновацын шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг дэмжих зэрэг тодорхой зорилтыг тусгаад байна.



Аж үйлдвэрийн IV хувьсгалын өнөө үед Монгол Улс мэдээллийн технологи, программ хангамж, үндэсний тоон контент болон газрын ховор элемент ашиглан электроникийн үйлдвэрлэл хөгжүүлж, экспортод гарган эдийн засгийн шинэ секторыг бий болгох шаардлагатай байна. Түүнчлэн уул уурхай, хөдөө аж ахуй давамгайлсан уламжлалт эдийн засгийн бүтцийг өндөр технологи, мэдлэг, инновацад суурилсан дижитал эдийн засгийн бүтцэд



Зураг 35. Мэдээллийн технологийн салбарын төлөв байдал



### МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН САЛБАРЫН ГАДААД ТӨЛӨВ БАЙДАЛ



Эх сурвалж: Монгол Улсын Засгийн Газар, 2021

шилжүүлэхэд салбар хоорондын хөгжлийг дэмжин ажиллах нь хөгжлийг хурдастагч хөшүүрэг болж байна.

Түүнчлэн инновац, өндөр технологийн кластер, үндэсний тоон контент үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх, мэдээллийн технологийн аж үйлдвэрийн парк байгуулах, их өгөгдөл, хиймэл оюун ухаан, юмсын интернэт, үүлэн технологи, блокчэйн зэрэг дэвшилтэй технологиудыг хэрэглээнд нэвтрүүлэх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалт бизнесийн таатай орчныг бүрдүүлэх, дижитал өрсөлдөх чадвар, нийгэм эдийн засгийн бүтээмжийг нэмэгдүүлэх бодлого барьж байна.

МХХТ-ийн салбарын нийт орлого

**1,263.2**

МХХТ-ийн салбарын нийт хөрөнгө оруулалт

**179.3**

МХХТ-ийн салбарын төсөвт төвлөрүүлсэн нийт орлого

**194.4**

ЭДИЙН ЗАСАГ

# УХААЛАГ САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛ

**ЗОРИЛГО 4.3** Олон улсын санхүүгийн зах зээлтэй холбогдсон олон тулгуурт, хүртээмжтэй санхүүгийн системийг хөгжүүлнэ.

ХӨГЖЛИЙН ҮЕ ШАТ · ХҮРЭХ ҮР ДҮН

**I ҮЕ ШАТ | 2021-2030**

Эдийн засгийг тэтгэсэн, уян хатан, цахим технологид суурилсан олон талт санхүүгийн үйлчилгээг хөгжүүлэх үе

**II ҮЕ ШАТ | 2031-2040**

Томоохон хөрөнгийн биржүүдтэй хамтран дотоодын санхүүгийн хэрэгслийг чөлөөтэй арилжаалах, мэргэжлийн тоглогчдын оролцоо, хөрөнгө оруулалт татах боломжийг бүрдүүлэх, дэлхийн хөрөнгийн зах зээлд оролцох түвшний цахим санхүүгийн тогтолцоог хөгжүүлэх үе

**III ҮЕ ШАТ | 2041-2050**

Санхүүгийн бүх төрлийн үйлчилгээг технологийн дэвшил, хиймэл оюун ухаанд суурилан дэлхийн түвшинд хөгжүүлэх үе

Блокчэйн алгоритм, виртуал валют, финтек зэрэг санхүүгийн инновац, дэвшилтэй технологийн үр нөлөө уламжлалт системд шинэлэг өөрчлөлтийг авчирч, төвлөрсөн бус тогтолцоонд дундын зуучлагчгүйгээр үйлчилгээ үзүүлэх хязгааргүй боломжийг бий болгон, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлж байна. Санхүүгийн системийн бүтцийг өөрчлөн төрөлжүүлж, хөрөнгийн зах зээл, даатгалын болон бичил санхүүгийн салбаруудыг өрсөлдөхүйц хэмжээнд хүргэж хүчирхэгжүүлэн, тогтвортой хөгжүүлснээр санхүүгийн хүртээмж, зах зээлийн хэмжээ тэлж гүнзгийрэн, эдийн засгийн өсөлтөд чухал үүргийг гүйцэтгэнэ.

Монгол Улсын санхүүгийн систем дэх нийт активын 90 гаруй хувь нь банкны салбарт ногддог. Өөрөөр хэлбэл, санхүүгийн салбарын гол тоглогч нь арилжааны банкнууд. Банкнаас бусад санхүүгийн салбарууд болох хөрөнгийн болон даатгалын зах зээл, бичил санхүүгийн салбарууд нийлээд 10 хувь хүрэхгүй буюу тун бага оролцоотой байна.


Санхүүгийн зах зээлийг чадавхжуулж, бүтээгдэхүүн үйлчилгээний чанар төрлийг нэмэгдүүлэх замаар олон тулгууртай, хүртээмжтэй болгох шаардлага байсаар байна.

Бодлогын хэрэгжилтийн хүрээнд санхүүгийн салбарыг жигд, тогтвортой өсгөж, бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрлийг





Зураг 36. Санхүүгийн салбарын бүтэц



Эх сурвалж: Сангийн яам, 2022

нэмэгдүүлэн чадавх, хууль эрх зүй болон хяналт, зохицуулалтын орчныг сайжруулахын зэрэгцээ санхүүгийн гэмт хэрэг, тэр дундаа терроризмыг санхүүжүүлэх, мөнгө угаахтай тэмцэх тогтолцоог боловсронгуй болгосны үндсэн дээр эрсдэл даах чадвар, найдвартай байдлыг хангана. Ингэснээр хөрөнгийн зах зээлийн үнэлгээ өсөж, биржээр арилжаалагдах бүтээгдэхүүний нэр төрөл, дүн хэмжээ өсөж, даатгалын салбарын тогтвортой байдал хангагдаж, эрсдэл үүрэх чадвар нэмэгдэж, хамрах хүрээ өргөжин банк бус санхүүгийн байгууллагууд болон хадгаламж, зээлийн хоршоодын удирдлага, менежментийн тогтолцоо сайжирч, үйлчилгээний хүртээмж тэлнэ. Эдгээр зорилтыг хангахын тулд хөрөнгийн зах зээлд арилжаа, төлбөр тооцооны дэд бүтцийг хөгжүүлж өргөжүүлэх, хөрөнгө оруулагчдын эрх ашиг, кибер аюулгүй байдлыг хамгаалах ухаалаг технологи нэвтрүүлэх, биржээр арилжаалагдах бүтээгдэхүүний нэр төрлийг олшуулж, хөрөнгийн зах зээлд тогтвортой байдал хангах, эрсдэлийн удирдлага, зохицуулалтын тогтолцоог сайжруулж, төлбөрийн чадварын стандартыг нэвтрүүлэх, урт хугацааны болон давхар даатгалын тогтолцоог боловсронгуй болгох стандартыг тогтоож, бүртгэлийн процессыг хялбаршуулах, кибер даатгалыг хөгжүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Харин бичил санхүүгийн салбарт төлбөрийн болон хяналтын системийг хөгжүүлж, эрсдэлийн удирдлагын тогтолцоо,

Санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг тэтгэж, зээлийн хүүг бууруулна.

Зураг 37. Олон тулгуурт санхүүгийн зах зээл

**ЭДИЙН ЗАСГИЙГ ТЭТГЭСЭН, ЦАХИМ ТЕХНОЛОГИД СУУРИЛСАН ОЛОН ТАЛТ САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ХӨГЖҮҮЛЭХ**




**ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ**

Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ, биржийн бус болон үүсмэл санхүүгийн зах зээл дээр хийгдэж буй арилжааны дүн нэмэгдсэн байна.



**ДААТГАЛЫН САЛБАР**

Даатгалын салбарын тогтвортой байдлыг хангах чиглэлээр эрх зүйн орчин бүрдэж, салбарын хамрах хүрээг нэмэгдүүлсэн байна.



**БИЧИЛ САНХҮҮ**

Бичил санхүүгийн байгууллагуудыг чадавхжуулан, эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулж, санхүүгийн зах зээлд зэлэх хувийн жинг нэмэгдүүлсэн байна.

Эх сурвалж: Сангийн яам, 2022

дэвшилтэт технологи нэвтрүүлэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, байгууллагуудыг чадавхжуулан бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрлийг олшруулах, хадгаламж зээлийн хоршоодод гишүүн төвтэй зохицуулалт хэрэгжүүлж, бичил банкны зохион байгуулалтад оруулах зэрэг үйл ажиллагааг төлөвлөсөн.

Санхүүгийн салбарыг бүхэлд нь эрсдэл багатай, хүртээмж өндөртэй болгох зорилгоор системд нөлөө бүхий арилжааны банкуудыг хувьцаат компанийн хэлбэрт оруулж, хувьцааг хөрөнгийн бирж дээр арилжаалдаг болно. Ингэж банкны систем дэх өмчлөлийн болон удирдлагын төвлөрлийг задлан, нээлттэй болгосноор олон нийтийн хяналтад орж, үйл ажиллагаа нь ил тод явагдах юм.

Санхүүгийн технологийн стандартуудыг зах зээлд нэвтрүүлж, Финтех буюу бүтээгдэхүүн үйлчилгээний цахим платформыг дэмжин хөгжүүлж, өртөг зардлыг бууруулснаар зээлийн хүү буурна. Нэгэнт финтех хөгжүүлж буй тохиолдолд тэдгээрийн зохицуулалт, хяналт шалгалтын үйл ажиллагааг цахимжуулах зохицуулалтын технологийг ч мөн хөгжүүлэх шаардлагатай. Технологийн дэвшил, их өгөгдөл суурилсан хяналт шалгалтын болон зохицуулалтын технологийг санхүүгийн салбарын зохицуулагч байгууллагуудын үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлж, олон улсад мөрдөж буй банкны хяналт шалгалт, зохицуулалтын зарчим, арга ажиллагааг мөрдлөг болгоно.

Зээлийн хүүг бууруулахын тулд технологийн шийдлийг нэвтрүүлэхийн зэрэгцээ мөнгөний хямд эх үүсвэрийг нэмэгдүүлэх, реформыг эрчимжүүлж, банк болон бусад санхүүгийн салбар

Иргэн, хуулийн этгээд хөрөнгийн биржийн арилжаанд сүүлийн үеийн дэвшилтэт технологид тулгуурласан, цахим арилжааны дэд бүтцээр шууд оролцох боломжийг бүрдүүлнэ.



хоорондын чөлөөт өрсөлдөөнийг сайжруулж, хэрэглэгчдэд сонгох боломж олгох зэрэг бодлогын зорилтыг хэрэгжүүлэхээр зах зээлийг төлөвлөж байна.

Салбаруудад технологийн дэвишийг тасралтгүй хөгжүүлж дэлхийн хөгжингүй орнуудын түвшинд хүргэн, үйлчилгээ, үйл ажиллагааг их өгөгдөл, хиймэл оюун ухаанд суурилсан платформоор гүйцэтгэж, аюулгүй байдал, нууцлал, ашиглалт, хамгаалалтыг биометрик мэдээллийн хяналтын системд бүрэн шилжүүлснээр УХААЛАГ ЗАХ ЗЭЭЛИЙН суурь бүрэлдэнэ. Эдгээрийн зэрэгцээ тэтгэврийн сан, тэтгэврийн даатгалын санг хөрөнгийн зах зээлийн мэргэжлийн оролцогч болгох бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үр дүнд нь Монголын хөрөнгийн зах өндөр үнэлгээтэй, олон улсад өрсөлдөхүйц, мэргэжлийн хөрөнгө оруулагчдын тоглох талбар болон хөгжиж, даатгалын болон бичил санхүүгийн захууд хэрэглэгч бүрийн хэрэгцээнд тохирсон бүтээгдэхүүн үйлчилгээтэй өндөр технологи бүрэн нэвтэрсэн салбар болж, санхүүгийн систем бүхэлдээ олон тулгуурт, хүртээмжтэй, дэлхийн зах зээлтэй нягт холбогдсон найдвартай тогтолцоотой болсон байх юм.

Зураг 38. Олон улсад өрсөлдөхүйц санхүүгийн зах зээл



Дотоодын давхар даатгал хөгжих, урт хугацааны даатгалын хүртээмжийг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлж, даатгалын салбарын эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулан салбарын тогтвортой өсөлтийг бүрдүүлнэ.

ЭДИЙН ЗАСАГ

# БҮС НУТГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА

**ЗОРИЛГО 4.3** Бүс нутгийн эдийн засаг, худалдааны интеграцад нэгдэж, худалдааг хөнгөвчилнө.

хөгжлийн үе шат • ХҮРЭХ ҮР ДҮН

**I ҮЕ ШАТ | 2021-2030**

Хөрш орнуудыг дамжсан эдийн засгийн коридорыг хөгжүүлэх, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Оросын Холбооны Улстай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулж, бүс нутгийн эдийн засаг, худалдааны интеграцад нэгдэх замаар эдийн засгийн гадаад харилцааг эрс нэмэгдүүлэх үе

**II ҮЕ ШАТ | 2031-2040**

Хөрш орнууд болон гуравдагч хөрш улсуудтай гадаад харилцааны тэнцвэртэй хөгжлийн түвшнийг хангах үе

**III ҮЕ ШАТ | 2041-2050**

Ази-Номхон далайн бүс нутаг дахь эдийн засаг, худалдааны интеграцад идэвхтэй оролцож, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар худалдааг нэмэгдүүлэх үе

Бүс нутгийн хамтын ажиллагааны зорилт нь гагцхүү гадаад харилцааны үзүүлэлт бүс эдийн засгийн өсөлт, тэр дундаа тэрүүлэх салбаруудын хөгжлийг илэрхийлэх хэмжүүр байх бөгөөд эрчим хүч, эко хүнс, эрдэс баялгийн эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлтээр Зүүн болон Зүүн хойд Азидаа тэргүүлж, санхүүгийн зах зээл, хөрөнгө оруулалтын томоохон төв болох юм.


Монгол Улс зөвхөн дотоодын хүч нөөцөөрөө богино хугацаанд эдийн засгаа тэлж, хөгжлийн бодлогоо хэрэгжүүлэн салбаруудаа төрөлжүүлэн хөгжүүлж, орлогоо нэмэгдүүлэхэд хүндрэлтэй. Бүтээмжийг дээшлүүлэхэд шаардлагатай технологи, эдийн засгийн өндөр өсөлтийг хангахад хүрэлцэхүйц санхүүгийн нөөц шаардлагатай тул гадаадын хөрөнгө оруулалтыг татан гадаад зах зээлтэй үндэсний үйлдвэрлэгчид, бизнес эрхлэгчдээ холбож, хамтран ажиллах зайлшгүй шаардлага тавигдаж буй юм.

Манай улс хөрш орнуудтай эдийн засаг, стратегийн харилцааг амжилттай удирдан явуулж “гуравдагч хөрш”-ийн гадаад бодлогын хүрээнд бусад улстай харилцаагаа бэхжүүлэн, ялангуяа Ази-Номхон далайн бүс нутгийн хамтын ажиллагаанд идэвхтэй оролцогч байж ирсэн. Гадаад харилцаанд олсон ололт амжилттаа бататгах замаар Хятад-Монгол-Оросыг дамжсан эдийн засгийн эсхүл тээврийн коридорыг хөгжүүлж, гуравдагч хөршүүдэд





Зураг 39. Гадаад худалдааны тэнцэл, оноор, тэрбум ам.доллар



Эх сурвалж: УСХ, 2022

хүрсэн эдийн засгийг бий болгон бүс нутгийн интеграцад нэгдэж, худалдааг хөнгөвчлөх зорилтыг нэн тэргүүнд хэрэгжүүлэхээр тусгасан нь дотоодын хязгаарлагдмал боломжоо нэмэгдүүлж, сул талаа нөхөх бидний давуу тал болно. Эдийн засгийн тэргүүлэх чиглэлүүд болон бусад салбарт тавьсан урт хугацааны зорилтуудаа хэрэгжүүлснээр хэтдээ дэлхийн түвшинд нэр хүнд бүхий өрсөлдөх чадвартай Зүүн хойд Азийн хөрөнгө оруулалтын гол төв болж, хөрш орнуудтай гадаад харилцааны тэнцвэртэй хөгжлийг хангасан байх юм.

Ази, Европыг холбосон эдийн засгийн коридор байгуулахын тулд “Бүс ба зам” санаачилгыг үр дүнтэй хэрэгжүүлж, Монгол Улсын газар нутаг дээгүүр дамжин өнгөрөх байгалийн хийн хоолойг барих асуудлыг гурван талт хэлэлцээрийн үр дүнд шийднэ. Тээвэр, логистик, хот байгуулалт, хил дамнасан худалдаа, аялал жуулчлалын дэд бүтцүүдээ байгуулж, чөлөөт бүсүүдээ хөгжүүлэн, гадаад худалдааны бүртгэл мэдээллийг цаасгүй технологид шилжүүлэх зэрэг өөрөөс шалтгаалах бүхнийг

Эдийн засгийн гадаад харилцаанд тэргүүлэх ач холбогдол өгч, төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан экспортыг нэмэгдүүлэх, төрөлжүүлэх, гадаад худалдаанд тулгарч байгаа хүндрэлүүдийг багасгах, хөнгөвчлөх бодлогыг үргэлжлүүлнэ.


### Экспорт

Монгол Улсын гадаад худалдааны түвш улсуудын тоо жилээс жилд нэмэгдэж, 2019 онд нийт 76 улсад бараа бүтээгдэхүүнээ экспортолж байна.

Зураг 40. Монгол Улсыг хөрш орнуудтай холбож буй коридорууд

дэс дараатай, эрчимтэй хэрэгжүүлэхийн зэрэгцээ харилцаа, хамтын ажиллагаатай улс орнуудтай эдийн засаг, худалдааны талаарх гэрээ хэлэлцээ байгуулж, түвшнийг ахиулж, тарифын болон тарифын бус саад totgorыг бууруулах арга хэмжээг эрчимтэй авч, гадаад харилцааныхаа хүрээг өргөжүүлнэ.

Тив дамнасан хамтын ажиллагаа, түншлэлийн түвшнийг ахиулах, агаарын карго тээврийн олон улсын логистикийн төв байгуулж, худалдаа аялал жуулчлал хөгжүүлэх зэрэг стратегийн, үндэсний онцлогтой бодлогуудыг хэрэгжүүлэхийн зэрэгцээ экспортын бүтээгдэхүүн, дотоод үйлдвэрийн брэнд гадаад зах зээлийн өрсөлдөөнөөс хамгаалж ажилласнаар эдийн застийн гадаад хамтын ажиллагаа гүнзгийрч, АПЕК зэрэг бус нутгийн болон бусад олон улсын байгууллагууд, Зүүн өмнөд, хойд Азийн орнуудтай харилцаагаа өргөжүүлж, 2050 онд жилийн нийт экспортын хэмжээг оны үнээр 140 тэрбум амдолларт хүрсэн байхаар тооцсон билээ.



Эх сурвалж: Үндэсний хөгжлийн газар, 2019



## ХУДАЛДААНЫ ИНТЕГРАЦИАЛ

Олон улсын харилцаа, хамтын ажиллагааны үндсэн арга хэрэгсэл нь гэрээ, конвенцоор харилцан тохиролцсон хэм хэмжээ, дүрэм журмыг баримтлах явдал юм. Манай улс зөвхөн худалдаа, эдийн засгийн чиглэлээр бус нутгийн болон олон улсын 30 гаруй гэрээ конвенцод нэгдэн орсон. Эдгээр нь үндэсний үйлдвэрлэгчид, бизнес эрхлэгчдийн олон улсын түншлэл, харилцаа, хамтын ажиллагааг хялбарчлах, хөнгөвчлөх болон хамгаалахад чиглэгдэж байна.

Хүснэгт 1. Монгол Улсын нэгдэн орсон худалдааны гэрээ, конвенцууд

1. Далайд гарцгүй улсын дамжин өнгөрөх худалдааны тухай конвенц /Convention on Transit Trade of Land-locked States/	1966
2. Олон улсын бараа худалдаад хөөн хэлэлцэх хугацааны тухай конвенц /Convention on the Limitation Period in the International Sale of Goods/	1974
3. Бараа худалдах-худалдан авах олон улсын гэрээний тухай конвенц /United Nations Convention on Contracts for the International Sale of Goods/	1999
4. Хөрөнгө оруулалтыг баталгаажуулах олон талт агентлагийг үүсгэн байгуулах конвенц /Convention establishing the Multilateral Investment Guarantee Agency (MIGA)/	1998
5. Олон талт худалдааны хэлэлцээний Уругвайн үе шатны үр дүн тусгасан төгсөлийн баримт бичиг /Final Act embodying the results of the Uruguay round of Multilateral Trade Negotiations/	1996
6. Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай Марракешийн хэлэлцээр /Marrakesh Agreement establishing the World Trade Organization/	1996
7. Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээр /General Agreement on Tariffs and Trade/	1997
8. Дэлхийн худалдааны байгууллагын эрх зүйн талаар зөвлөх төв байгуулах тухай хэлэлцээр /The Agreement establishing the Advisory Centre on WTO Law/	2020
9. Олон улсын худалдааны мэдээлэл, хамтын ажиллагааны агентлагийг Засгийн газар хоорондын байгууллага болгон байгуулах тухай хэлэлцээр /Agreement establishing the Agency for International Trade Information and Co-operation as an Intergovernmental Organization/	2005
10. Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк үүсгэн байгуулах хэлэлцээр /Articles of Agreement of the Asian Infrastructure Investment Bank/	2015
11. Төв Азийн бус нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны институцийг үүсгэн байгуулах тухай хэлэлцээр /Agreement Establishing the Central Asia Regional Economic Cooperation Institute/	2017
Эдийн засгийн хамтын ажиллагааны олон улсын банк үүсгэн байгуулах, түүний үйл ажиллагааны тухай 1963 оны хэлэлцээр болон Эдийн засгийн хамтын ажиллагааны олон улсын банкны дурэмд өөрчлөлт оруулах тухай 2014 оны протокол /Protocol of 2014 amending the Agreement concerning the organization and the activities of International Bank for Economic Cooperation and the Statutes of the International Bank for Economic Cooperation/	2017
13. Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээр /Asia-Pacific Trade Agreement/	2020
14. Ази, Номхон далайн хил дамнасан цаасгүй худалдаа хөнгөвчлөх тухай ерөнхий хэлэлцээр /Framework Agreement on Facilitation of Cross-border Paperless Trade in Asia and the Pacific/	2022
15. Гаалийн хамтын ажиллагааны зөвлөл байгуулах тухай конвенц /Convention Establishing a Customs Cooperation Council/	1991
16. Барааг тодорхойлоо, кодлох уялдуулсан системийн тухай Брюсселийн хэлэлцээр /Agreement of the Harmonized Commodity Description and Coding System/	1993
17. ТИР Карнегийг хэрэглэн барааг олон улсын хэмжээнд тээвэрлэх тухай конвенц /Customs Convention on the International Transport of Goods under Cover of TIR Carnets (TIR Convention)/	2002
18. Гаалийн бүрдүүлэлтийн горимыг хялбарчлах, уялдуулах тухай олон улсын конвенц /International Convention on the simplification and harmonization of Customs procedures (Kyoto Convention)/	2006
19. Барааны хилийн хяналтын үйл ажиллагааг уялдуулах тухай олон улсын конвенц /International Convention on the Harmonization of Frontier Controls of Goods/	2007
20. Гаалийн тариф барааны ангилал нэршилийн тухай конвенц, түүнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай протокол /Convention on Nomenclature for the classification of goods in Customs tariffs and Protocol of Amendment thereto/	2007
21. Бараа, тээврийн хэрэгслийг түр хугацаагаар оруулах тухай Истанбулын конвенц /The Convention on Temporary Admission, Istanbul/	2003
22. Хурайр бoomтын тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр /Intergovernmental Agreement on Dry Ports/	2016
23. Татварын асуудлаар захиргааны туслацаа харилцан үзүүлэх тухай конвенц /Convention on Mutual Administrative Assistance in Tax Matters/	2020
24. Олон улсын гэрээнд цахим харилцааг ашиглах тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенц /United Nations Convention on the Use of Electronic Communications in International Contracts/	2021
25. Эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны харилцаанаас үүссэн иргэний эрх зүйн маргааныг арбитраар шийдвэрлүүлэх тухай конвенц /Convention on the settlement by Arbitration of civil law disputes resulting from relations of Economic and Scientific-technical cooperation/	1973
26. Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай конвенц, Нью Йорк /Convention on the Recognition and Enforcement of Foreign Arbitral Awards, New York/	1994
27. Улс болон гадаад улсын иргэний хооронд хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх тухай конвенц, Вашингтон /Convention on the Settlement of Investment Disputes Between States and Nationals of Other States, Washington/	1991
28. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай конвенц, Haar /Convention on Civil Procedure, The Hague/	2014
29. Далайд гарцгүй хөгжжик буй орнуудын Олон улсын судалгааны төв байгуулах тухай олон талт хэлэлцээр /Multilateral Agreement for the Establishment of an International Think Tank for landlocked Developing Countries/	2011

Эх сурвалж: ГХЯ, 2022

## ЭДИЙН ЗАСАГ

# ӨРСӨЛДӨХ ЧАДВАРТАЙ БРЭНД БҮТЭЭГДЭХҮҮН

**ЗОРИЛГО 4.5** Олон улсад өрсөлдөх чадвартай бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг хөгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.

## ХӨГЖЛИЙН ҮЕ ШАТ • ХҮРЭХ ҮР ДҮН

**I ҮЕ ШАТ | 2021-2030**

Бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийг инновацад тулгуурлан хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлэх үе

**II ҮЕ ШАТ | 2031-2040**

Бус нутгийн болон олон улсын чанар, стандартын тогтолцоог нэвтрүүлэх, цахим худалдааг хөгжүүлэх замаар бус нутгийн нэмүү өргтийн сүлжээнд холбогдож ажиллах үе


**III ҮЕ ШАТ | 2041-2050**

Технологийн дэвшил, ур чадвартай хүний нөөц, цахим худалдаанц тулгуурлан дэлхийд өрсөлдөх чадвартай инновацад суурилсан брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэж, нийлүүлэх үе

Брэнд гэдэг нь аливаа бүтээгдэхүүн үйлчилгээний бусдаасаа илт давуу ялгарч, хэрэглэгчдийн сэтгэл ханамжид зүй ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн, ялган танихад зориулагдсан нэр томьёо, тэмдэг лого, дизайны хослол билээ. Брэндийн шинж чанар нь товчондоо ялгарал, чанар, итгэл, хүлээлт, эдэлгээ, найдвартай байдал, сэтгэл ханамжийн нэгдэл юм.

Судалгаа шинжилгээ, шинэ санаа, оюуны бүтээл, брэндэд тулгуурласан гадаад зах зээлд чиглэсэн үйлдвэрлэл Монгол Улсын нүүр царай билээ. Өрсөлдөөнд ялгарах брэнд бүтээгдэхүүнийг бүтээж, дэлхийн зах зээлд таниулахад брэнд бүтээгдэхүүн гэх ойлголт Монгол Улсын бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийн бүтээмжийг илэрхийлдэг, өндөр чанар, тансаг зэрэглэл, байгалийн цэвэр органик орц найрлагыг илтгэдэг, манай улсын нэрийн хуудас, нууц жор, танигдахуй, ялгарахуй байх учиртай.

Аж үйлдвэржүүлэх бодлого, эдийн засгийн тэргүүлэх чиглэлийн хөгжлийн зорилтуудыг хангахдаа хүнд, хөнгөн болон бичил, жижиг, дунд үйлдвэр, боловсруулах салбар, бүтээлч үйлдвэрлэл, анагаах ухаан, аялал жуулчлал, тээвэр логистик, эдийн засгийн бүсчлэл, гадаад, дотоод худалдааны харилцаанд





хүртэл брэндийн баримжааг агуулж, бүтээгдэхүүний чанар стандартыг сайжруулан шинжлэх ухаан, дэвшилтэт технологи, инновац, үндэсний онцлог болон монгол хүний оюуны бүтээлч чанар, ур чадварыг шингээнээр дэлхийн хэмжээний томоохон брэндийг бүтээх боломж бүрдэнэ. Энэ зорилтыг хэрэгжүүлэхэд хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, татварын бодлого, банк санхүүгийн тогтолцоогоор дамжуулан хувийн хэвшлийн хөгжлийг дэмжих төрийн үүрэг оролцоогоор зогсохгүй монгол хүн бүхний оюун сэтгэлгээ, санаачилга, хөдөлмөр зүтгэл нэгдэн нийлж байж үндэсний компани, үндэсний брэнд бүтээгдэхүүнийг бий болгож, хөгжүүлж чадна. Хөгжлийн бодлогын шийдвэрлэх шатанд Монгол Улс Азид эдийн засгийн идэвхтэй оролцогч болсон байх ба үйлдвэрлэл бизнестээ бус нутгийн болон олон улсын чанар, стандартын тогтолцоог нэвтрүүлэн цахим худалдааг хөгжүүлэх замаар экспорт тоо төрөлжүүлснээр инновацад суурилсан брэнд бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлнэ.

Энэ том зорилтыг хэрэгжүүлэхэд эхний ээлжид инновац, технологи нэвтрүүлэх, мэдлэг хуваалцах болон үйлдвэрлэл,

Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд дэлхийн өргтийн сүлжээнд тавигддаг шаардлагуудыг хангах удирдлагын болон ажиллах хүчний ур чадварыг дээшлүүлж, технологийн дэвшил, инновацыг нэвтрүүлж, бүтээгдэхүүний чанар, стандартыг сайжруулна.

хөрөнгө оруулалтын чиглэлээр төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд ажиллах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно. Эдийн засагт цахим салбарыг хөгжүүлэх бодлого, хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ. Бизнес инкубатор төвүүд байгуулж, жижиг, дунд үйлдвэрлэгчдийн хөгжлийг дэмжих институцийн тогтолцоог бүрдүүлж, тэдгээрийн хүний нөөцийн ур чадварыг дээшлүүлж, үйл ажиллагааг дэмжинэ. Үйлдвэрлэлд автоматжуулалт, технологи болон мэдээлэл технологийн дэвшил, ололтыг нэвтрүүлэх ажил тасралтгүй явагдах бөгөөд нанотехнологи, биотехнологи болон ногоон технологи, оюуны бүтээлд тулгуурласан байгаль орчинд ээлтэй органик бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих, эдгээрт хөрөнгө оруулах таатай орчныг бүрдүүлэхэд төрийн бодлого чиглэнэ.

Монголын жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд дэлхийн өргтийн сүлжээнд тавигддаг шаардлагыг хангах удирдлагын болон ажиллах хүчний ур чадвар суулгах, шаардлагатай технологи, инновацын талаар мэдээлэл авах сургалт, уулзалтыг бодлогоор зохион байгуулж, олон улсын үзэсгэлэн яармаг, бизнес форумыг гадаад оронд суугаа дипломат төлөөлөгчийн газруудаар дамжуулан зохион байгуулж, хөрөнгө оруулалтын түншлэлийг өргөжүүлнэ. Төрийн болон олон улсын байгууллагаас жижиг, дунд үйлдвэрийн салбарт олгож буй зээл, тусlamжийн санхүүжилтийг үр ашигтай

Зураг 41. Үндэсний брэнд бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ





болгох үүднээс оролцогч талуудын уялдааг сайжруулах, лизинг болон факторинг зэрэг санхүүжилтийн бусад эх үүсвэрийн хэрэглээг нэмэгдүүлж, экспортод чиглэсэн үйлдвэрлэл эрхлэгчдэд зориулсан батлан даалт, даатгалыг нэвтрүүлнэ.

Бичил, жижиг, дунд үйлдвэрийг дэмжих том аж ахуйн нэгж, үйлдвэрлэгчдийн санаачилгыг урамшуулах замаар кластерын хөгжлийг хангахын зэрэгцээ бүс нутгийн эдийн засгийн хөгжлийг дэмжих дэд бүтэц, аж үйлдвэрийн цогцолборыг барьж байгуулан, чөлөөт бүсийг хөгжүүлж, эдгээр бүсийг холбосон үндэсний брэнд худалдааны сүлжээ болон хил дамнасан худалдааны байнгын сүлжээг бий болгоно.

Энэ бүхэн эцсийн дүндээ дэлхийд өрсөлдөх чадвартай үндэсний брэнд бүтээгдэхүүн, жижиг, дунд үйлдвэрийн салбарыг бий болгож, хөгжүүлэхэд чиглэх бөгөөд үүний дотор бүтээлч үйлдвэрлэлийн салбарт брэнд бүтээгдэхүүн бий болгох явдал бол уг зорилтын нэг томоохон чиглэл юм. Оюуны болон соёлын өвийг бүтээгч хувь хүн, баг, хамт олныг дэмжиж, дэлхийд таниулах, тэдний залгамж халааг бэлтгэхэд бодлогын дэмжлэг үзүүлж, тэдний бүтээсэн оюуны болон соёлын биет бус өвийн бүтээлүүд, түүнийг дагасан уламжлал, ёс заншил, үндэсний онцлог бүхий брэнд үйлдвэрлэлийг хөгжүүлж экспортлох боломжийг нэмэгдүүлнэ.



Кластерын хөгжил

Чөлөөт бүс, хил дамнасан худалдааны байнгын сүлжээ

Бүтээгдэхүүний чанар, стандарт

Олон улсын үзэсгэлэн, яармаг болон бизнес уулзалтууд

Үйлдвэрийн нийгмийн хариуцлага

Дэлхийд өрсөлдөх чадвартай, инновацад сууринсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл

Дэлхийн өргтгийн сүлжээнд тавигддаг шаардлагуудыг хангасан бүтээгдэхүүн

Нано болон ногоон технологи, оюуны бүтээл

Байгаль орчинд ээлтэй органик бүтээгдэхүүн



Экспортыг дэмжих санхүүгийн шийдлүүдийг боловсруулж, экспортод гаргах бараа, бүтээгдэхүүний хэмжээт нэмэгдүүлнэ.

ЭДИЙН ЗАСАГ

# ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САН

**ЗОРИЛГО 4.6** Эдийн засгийн төрөлжилт, инновац, шинэ технологи, хүний хөгжил, ногоон хөгжлийн зорилтуудыг дэмжих чадавхтай олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн баялгийн санг бий болгоно.

ХӨГЖЛИЙН ҮЕ ШАТ • ХҮРЭХ ҮР ДҮН

I ҮЕ ШАТ | 2021-2030

Баялгийн сан байгуулж,  
санхүүгийн үр ашигтай  
төсөл хөтөлбөрүүдэд  
хөрөнгө оруулалт хийх үе

II ҮЕ ШАТ | 2031-2040

Нийгэм-эдийн засгийн хөгжлийг дэмжих  
төсөл, хөтөлбөр болон гадаадын  
санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах  
замаар эдийн засгийг дэмжих, баялгийн  
сангийн хөрөнгийг арвижуулах үе

III ҮЕ ШАТ | 2041-2050

Эдийн засгийн төрөлжилт, инновац,  
шинэ технологи, ногоон хөгжлийн  
зорилтуудыг дэмжих чадавхтай олон  
улсад хүлээн зөвшөөрөгдсөн баялгийн  
санг төлөвшүүлэх үе

Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлүй, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн. Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлүйн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ.

Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг

Байгалийн баялаг тухайн улс орондоо үр өгөөжтэй байх эсэхийг нь тагцхүү төрийн холч бодлого, тууштай хэрэгжилт шийдэж иржээ. Баялгаас олж буй орлогоо эдийн засгийг дэмжих хөдөлгүүр болгон үр дүнтэй зарцуулж, иргэдийн амьдралд бодит нөлөө үзүүлэхүйц тэгш хүртээмжтэй хуваарилан, болзошгүй хямрал, эрсдэлийг даахуйц тогтвортой, хэлбэрэлтгүй бодлогыг баримталж чадсан эсэхээс хамаарч хөгжил нь тодорхойлогддогийг дэлхийн улс орны туршлагаас харж болно.

Эдүгээ дэлхий дахинд байгалийн баялгийн топ 100 санд 10.0 их наяд ам.доллар хадгалагдан, хөрөнгө оруулалт хийгдэж байна. Сангуудын зориулалт, чиг үүрэг нь тухайн улсын хөгжлийн





шаардлагатай уялдан, эдийн засгийн хямралаас хамгаалж төсвийг тогтвржуулах, өгөөжийг хуваарилах буюу ногдол ашиг түгээх, хөгжилд чиглэсэн хөрөнгө оруулалт хийх гэх мэт олон төрөл байна. Зарим улс өдгөэр санг хэд хэдээр нь байгуулсан байх бөгөөд түүхий эдийн дэлхийн зах зээл дээрх үнийн өсөлтөөс үүдэж нэмэгдсэн орлогыг тодорхой хувь хэмжээгээр хуваарилан төвлөрүүлдэг.

Хэдийгээр олон төрийн зориулалттай ч төрийн эзэмшилд байж, макро эдийн засгийн тогтвортой байдлыг дэмжих, тэгш хүртээмжтэй хуваарилах зэрэг хэд хэдэн шинж баялгийн сангуудад нэгэн ижил байна. Гэхдээ төрийн эзэмшилд байх зарчим нийтлэг ч гэлээ улс төрийн амлалт үүргээс хол байлгах зохицуулалтыг хуульчилж өгдөг нь мөнхүү нийтлэг шинж билээ.

Баялгийн санг амжилттай хөгжүүлсэн улсын нэг нь Норвеги. Дэлхийн топ 100 санд хуримтлагдаад байгаа 10.0 их наяд амдолларын арав гаруй хувь нь Норвегийн сангийн хөрөнгө юм. Тус сан 1967 онд байгуулагдсан бөгөөд 1990 оноос олон улсын түвшинд ажиллаж эхэлсэн. Эдүгээ тус сан хөрөнгө оруулалтынхаа 60 хувийг хувьцааны зах зээлд өргөлдүүлж, тогтмол үр ашигтай ажилладаг. Норвегийн хүн амын 90 гаруй хувь нь чинээлэг дундаж давхаргад багтаж, дэлхийн амар тайван, сэтгэл хангалиун орны жагсаалтыг тэргүүлэх болсон.

Зураг 42. Баялгийн сангийн төрлүүд

	Тогтвржуулалтын сан	Хадгаламжийн сан	Нөөцийн сан	Хөгжлийн сан																						
<b>Зорилго</b>	Эрдэс баялгийн дэлхийн зах зээлийн үнийн хэлбэлзэл болон гадаад хүчтэй нөлөөлөөс до тооны эдийн засаг болон төсвөө хамгаалах	Нэхөн сэргээгдэхгүй баялгийг төрөлжсөн санхүүгийн бүтээгдэхүүнд хөрөнгө оруулалт хийж, ирээдүй үедээ өвлүүлж хүртээх	Хуримтлал үүсгэн ирээдүйн нийгэм-эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, шинэчлэлийн хүрээнд үүссэн урт хугацааны төсвийн өр төлбөрийг нөхөх	Дэд бүтэц болон тэргүүлэх ач холбогдолтой дотоодын төслүүдэд хөрөнгө оруулалт хийж замаар эдийн засгаа дэмжих																						
<b>Хөрөнгө оруулалтын хугацаа</b>	Богино хугацааны	Урт хугацааны	Урт хугацааны	Дунд болон урт хугацааны																						
<b>Хөрөнгө оруулалтын бүрдэл</b>	Хөрвөх чадвар сайтай хөрөнгө оруулалтаас бүрдэх	Төрөлжсөн хөрөнгө оруулалтаас бүрдэх	Төрөлжсөн хөрөнгө оруулалтаас бүрдэх	Төрөлжсөн хөрөнгө оруулалтаас бүрдэх																						
<b>Жишиг сангуд</b>	<table border="0"> <tr> <td></td> <td>Чили</td> </tr> <tr> <td></td> <td>Орос</td> </tr> <tr> <td></td> <td>Перу</td> </tr> </table>		Чили		Орос		Перу	<table border="0"> <tr> <td></td> <td>АНЗУ</td> </tr> <tr> <td></td> <td>Австрали</td> </tr> <tr> <td></td> <td>Хятад</td> </tr> </table>		АНЗУ		Австрали		Хятад	<table border="0"> <tr> <td></td> <td>Чили</td> </tr> <tr> <td></td> <td>Кирibati</td> </tr> </table>		Чили		Кирibati	<table border="0"> <tr> <td></td> <td>Казахстан</td> </tr> <tr> <td></td> <td>Сингапур</td> </tr> <tr> <td></td> <td>Ирланд</td> </tr> </table>		Казахстан		Сингапур		Ирланд
	Чили																									
	Орос																									
	Перу																									
	АНЗУ																									
	Австрали																									
	Хятад																									
	Чили																									
	Кирibati																									
	Казахстан																									
	Сингапур																									
	Ирланд																									

ЭДИЙН ЗАСАГ

## ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САН

Монгол Улс үндэсний хуримтлалын талаарх төрийн бодлогодоо өөрчлөлт оруулж, баялгийн орлогыг хөгжилд чиглүүлэх шинэ чиглэл баримтлах зорилт дэвшүүлсэн. Энэ нь эдийн засгийн төрөлжилт, инновац, шинэ технологи, хүний хөгжил, ногоон хөгжлийг дэмжих чадавхтай, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн баялгийн санг бий болгох зорилт юм. Баялгийн сангаа байгуулж, эхний ээлжид үр ашигтай төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх, хөрөнгө оруулах зарчмаар хуримтлалыг нэмэгдүүлэх бодлогын нэгдмэл удирдлагыг хэрэгжүүлнэ. Хууль эрх зүйн орчныг төгөлдөржүүлж, засаглалын зохистой зарчмыг баримтлан бодитой эх үүсвэрээс хөрөнгө төвлөрүүлэх ажлыг эхлүүлснээр сангийн үйл ажиллагааны үндэс суурийг тавьж, цаашид нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих мега төслүүдэд хөрөнгө оруулалт хийх, иргэдийн амьжирагааг тогтвортой дээшлүүлэх хэмжээний чадавхыг бүрдүүлж ажиллах юм. Үндэсний болон гадаадын санхүүгийн хэрэгслүүдэд хөрөнгө оруулалт хийх түвшинд хүрснээр сан мэргэжлийн хөрөнгө оруулагч болж, хуримтлал олон эх үүсвэрээс хурдтай арвижих боломжтой болно.

Баялгийн сангийн хөрөнгөөр дотогшоо чиглэсэн санхүүгийн үр ашигтай хөрөнгө оруулалт хийхдээ эдийн засгийн төрөлжилтийг хангах, иргэдийн аюулгүй байдал, тав тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор уул уурхай, түүнийг дагасан дэд бүтэц болон бусад санхүүгийн үр өгөөжтэй томоохон төслүүдийг санхүүжүүлэх, нэмүү өртөг шингээсэн дотоодын үйлдвэрлэлийг

Зураг 43. Үндэсний баялгийн сангийн ажиллах зарчим

### ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САН



#### ЭРДЭНЭС МОНГОЛ

- Төрийн өмчийн хөрөнгийг зохистой удирдах
- Охин компаниудын засаглалыг сайжруулах замаар оновчтой хөрөнгө оруулалт хийх
- Охин компаниудын үр өгөөжийг нэмэгдүүлж, төсөвт төвлөрүүлэх орлогыг нэмэгдүүлэх.



#### ИРЭЭДҮЙН ӨВ САН

- Баялгийн үр өгөөжийг хойч үедээ өвлүүлэх
- Сангийн хөрөнгийг зөв удирдаж, олон улсын зах зээл дээр үнэ цэнийг нэмэгдүүлэх.



#### УЛСЫН ТӨСӨВ

- Төсвийн тогтвортжуулалтын сан
- Иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх



хөгжүүлж, ажлын байр нэмэгдүүлэх, дундаж давхаргыг тэлэх, олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгоходо мэдлэгийн эдийн засгийг дэмжих зарчим баримтална.

Монгол Улсын Үндсэн хуулийн 2019 оны нэмэлт өөрчлөлтөөр байгалийн баялгийн ашиглалттай холбоотой суурь зарчмыг баталсантай холбогдуулан ирээдүй хойч үедээ өвлүүлэх, гадаадад хөрөнгө оруулалт хийх чиг үүрэг бүхий хуримтлалын буюу Ирээдүйн өв сан болон байгалийн баялгаас төвлөрүүлсэн хөрөнгөөр дотоодод үр ашигтай хөрөнгө оруулалт хийж, байгалийн баялгийн үр өгөөжийг арвижуулж, ногдол ашиг хуваарилах зорилго бүхий Хөгжлийн сангаас бүрдэнэ. Байгалийн баялгийг ашиглах төрийн хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээх, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг Үндсэн хуулиар тогтоосон юм.

Ийнхүү баялгийн сан нь санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг сайжруулах, үндэсний валютын ханшийг тогтвортой түвшинд барих, Монгол Улсын зээлжих зэрэглэлийг нэмэгдүүлэх, үндэсний баялгаа арвижуулах, үр өгөөжийг нь одоо ба ирээдүй үед санхүүгийн өгөөжтэйгөөр тэгш, шударга хүртээх зэрэг эерэг үр нөлөө бий болно.

### ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЧИГЛЭЛ

Дотоодын хөрөнгө оруулалт стратегийн хувьд ач холбогдол бүхий томоохон теслүүдэд хөрөнгө оруулалт хийж, урт хугацааны эдийн засгийн тогтвортой өсөлтийг бий болгоно.



Эх сурвалж: УУХҮЯ, 2022

## ЭХ СУРВАЛЖ, АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Монгол Улсын Их Хурал. (1992). Монгол Улсын Үндсэн хууль. УБ.

Монгол Улсын Их Хурал. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. УБ.

Монгол Улсын Засгийн Газар. (2021). "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичгийн танилцуулга. УБ.

Гадаад харилцааны яам. (2022). Салбарын танилцуулга. УБ.

Дэлхийн эдийн засгийн форум. (2019). Аялал жуулчлалын өрсөлдөх чадварын үзүүлэлт.

Зам, Тээврийн хөгжлийн яам. (2022). Салбарын танилцуулга. УБ.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын төсөл боловсруулах Ажлын хэсэг. (2019). Монгол Улсын ДНБ ба нэг хүнд ногдох ДНБ-ий хэтийн тооцоо. УБ.

Монголын Эдийн Засгийн Форум. (2022). Илтгэл танилцуулга. УБ.

Л.Оюун-Эрдэнэ. (2021). Азийн хүлэг улс, Алсын хараа-2050. УБ.

Сангийн яам. (2022). Салбарын танилцуулга. УБ.

Соёлын яам. (2022). Салбарын танилцуулга. УБ.

Үндэсний Статистикийн Хороо. (2022). Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. УБ.

Үндэсний хөгжлийн газар. (2019). Салбарын танилцуулга. УБ.

Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн яам. (2022). Салбарын танилцуулга. УБ.

Уул уурхай, Хүнд үйлдвэрийн яам. (2022). Салбарын танилцуулга. УБ.

Эдийн засаг, Хөгжлийн яам. (2022). Салбарын танилцуулга. УБ.

Эрчим Хүчний Яам. (2022). Салбарын танилцуулга. УБ.

PricewaterhouseCoopers LLP. (2022). The Long View How will the global economic order change by 2050? <https://www.pwc.com/gx/en/world-2050/assets/pwc-world-in-2050-summary-report-feb-2017.pdf>

Sovereign Wealth fund Institute. (2022). Top 100 Largest Sovereign Wealth Fund Rankings by Total Assets. <https://www.swfinstitute.org/fund-rankings/sovereign-wealth-fund>

UNITED NATIONS ESCAP. (2022). Transport Infrastructure Connectivity in Asia and the Pacific. [https://www.unescap.org/sites/default/files/Secretariat\\_Mr.%20Weimin%20Ren.pdf](https://www.unescap.org/sites/default/files/Secretariat_Mr.%20Weimin%20Ren.pdf)

## Товчилсон үгсийн жагсаалт

АНУ	Америкийн Нэгдсэн Улс	ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс	УУХҮЯ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
БОАЖЯ	Байгаль орчин аялал жуулчлалын яам	ҮНО	Үндэсний нийт орлого
БНУЗҮ	Бүгд Найрамдах Узбекистан Улс	ҮСХ	Үндэсний статистикийн хороо
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс	ЭЭХЯ	Эдийн засаг хөгжлийн яам
ББЭХС	Баруун бүсийн эрчим хүчний сүлжээ	ЭХС	Эрчим хүчний сүлжээ
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн	ЦДАШ	Цахилгаан дулааны агаарын шугам
ДЭЦ	Дулааны эрчим хүч	ОХУ	Оросын Холбооны Улс
ЗГ	Засгийн газар	ӨБҮЦС	Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ
МАА	Мал аж ахуй	ХАА	Хөдөө аж ахуй
МХХТ	Мэдээлэл харилцаа, холбооны технологи	САА	Сангийн аж ахуй
ТУХН	Тусгаар улсуудын хамтын нийгэмлэг	ЦЭХ	Цахилгаан эрчим хүч
ТБНС	Төвийн бүсийн нэгдсэн сүлжээ	Гкал	Гегэ калорь
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	СБҮ	Соёлын бүтээлч үйлдвэрлэл